

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

АНХНЫ ӨРӨГТ ГҮҮСЭЛГЭЭН ПЛЭГЧ



БИЧИЛ ГЛОБУС  
САНХУУГИЙН БАЙГУУЛЛАГА

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



# БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС


20 ТЭРБУМ



**БҮРТГЭВ-02**

Агуулга

Үнэт цаасны танилцуулга



ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ .....	6
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД .....	10
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	11
ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	13
ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД .....	14
<b>НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН.....</b>	<b>15</b>
1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ.....	16
1.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ .....	22
1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ .....	23
1.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ .....	25
<b>ХОЁР. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ.....</b>	<b>26</b>
2.1. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ .....	27
2.2. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	29
2.3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ .....	30
2.4. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ .....	32
2.5. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ.....	37
2.6. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	45
<b>ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....</b>	<b>48</b>
3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА .....	49
3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	50
3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	57
3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ.....	57
3.5. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ .....	61
3.6. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БУЦААН ХУДАЛДАХ НӨХЦӨЛ .....	62
<b>ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ .....</b>	<b>67</b>
4.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ .....	68
4.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ .....	70
4.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ .....	72
4.4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ.....	73
4.5. ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ .....	76
4.6. ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ .....	78





2024 -03- 25

4.7. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ХҮНИЙ НӨӨЦ, ПРОГРАММ  
ХАНГАМЖИЙН ТУХАЯА 02

Үнэт цаасны танилцуулга

он 2024 сар 03 25  
желдер

БҮРГГЭВ № 01

87

4.8. ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ.....	90
4.9. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	90
<b>ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН .....</b>	<b>96</b>
5.1. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН .....	97
5.2. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМУУД.....	99
<b>ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА .....</b>	<b>101</b>
6.1. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР.....	102
6.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР.....	102
6.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ .....	103
6.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ.....	104
6.5. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ.....	104
<b>ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ .....</b>	<b>108</b>
7.1. АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ.....	109
7.2. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ.....	112
7.3. ЗЭЭЛИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ .....	114
7.4. ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ.....	116
7.5. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	118
<b>НАЙМ. ХАВСРАЛТ .....</b>	<b>119</b>
8.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ .....	120
8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ.....	122
8.3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ .....	127
8.4. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ.....	134
8.5. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ.....	142
8.6. АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ .....	146
8.7. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ .....	147
8.8. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ .....	149
8.9. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭ .....	169
8.10. ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ.....	183
8.11. ЗЭЭЛИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ.....	199
8.12. ХУУЛИЙН ФИРМИЙН ДҮГНЭЛТ .....	215
8.13. НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ .....	

МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ  
АШИГ СОНИРХЛЫН  
ТАЛААРХ  
МЭДЭГДЭЛ

АТААЛ 032-8419868  
03010482

ОУЗНИЙ Энд Ко  
Капитал  
240

5183856  
9021031195 СТС2420  
2



## График

График 1. Монгол Улсын Бодит ДНБ-ийн өсөлт, хувиар.....	16
График 2. Инфляц ба бодлогын хүү .....	17
График 3. 2024 оны инфляцын төсөөлөл .....	17
График 4. Мөнгөний нийлүүлэлт ба заавал байлгах нөөцийн хувь.....	18
График 5. Зээлийн өрийн үлдэгдэл, их наяд төгрөг.....	18
График 6. Зээлийн хүү ба хадгаламжийн хүү.....	19
График 7. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд, сая ам.доллар .....	19
График 8. Ам.долларын ханшийн өөрчлөлт.....	20
График 9. Гадаад валютын улсын нөөц (ГВУН), сая ам.доллар .....	20
График 10. Монгол Улсын төсвийн орлого ба зарлага, (их наяд төгрөг) .....	21
График 11. Ажилгүйдлийн түвшин.....	21
График 12. Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс.....	22
График 13. Зах зээлийн үнэлгээ, (их наяд төгрөг) ба ДНБ-тэй харьцуулсан харьцаа.....	22
График 14. Нийт хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг).....	23
График 15. Нийт өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг) .....	23
График 16. Зээлийн багц (тэрбум төгрөг) ба чанааргүй зээлийн хувь .....	24
График 17. Банк бус санхүүгийн салбарын нийт орлого, нийт зарлага ба цэвэр ашиг (тэрбум төгрөг) .....	24
График 18. Нийт хөрөнгө (тэрбум төгрөг) ба хөрөнгийн өсөлт (хувиар) .....	38
График 19. Нийт хөрөнгийн бүтэц, актив талаас (тэрбум төгрөг) .....	38
График 20. Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас (тэрбум төгрөг) .....	38
График 21. Өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг) .....	39
График 22. Зээлийн багцын чанар, (хувиар) .....	39
График 23. Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг, (тэрбум төгрөг).....	41
График 24. Ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөжийн харьцаа үзүүлэлтүүд .....	41
График 25. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг) .....	43
График 26. Инфляц ба бодлогын хүү.....	71
График 27. Системийн нөлөө бүхий банкнуудын төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү .....	71
График 28. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны жилийн өгөөж.....	72
График 29. Хөрөнгийн багц дахь зээлийн анх олгосон хэмжээ (сая.төг) ба эзлэх хувийн тархалт.....	81
График 30. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдлийн тархалт, сая төгрөг .....	81
График 31. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангиллаар .....	82
График 32. Хөрөнгийн зээлийн багцын үлдэгдлийн тархалт, (сая төгрөг ба хувь) .....	83
График 33. Хөрөнгийн багц дахь анх зээл олгосон огнооны тархалтаар .....	83
График 34. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацааны тархалт.....	84

## Хүснэгт

Хүснэгт 1. БНХАУ ба Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал.....	16
Хүснэгт 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл .....	16





2024 -03- 25

Хүснэгт 3. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл  
**БҮРТГЭВ-02**

Үнэт цаасны танилцуулга

2024.03.20

Одбор

ЦУРСГЭВ

28

Хүснэгт 4. Компанийн түүх.....	28
Хүснэгт 5. Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Төлөөлөн удирдах зөвлөл .....	31
Хүснэгт 6. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх удирдлагын баг .....	32
Хүснэгт 7. Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг) .....	37
Хүснэгт 8. Нийт зээлийн бүтэц, бүтээгдэхүүний төрлөөр .....	40
Хүснэгт 9. Орлого, үр дүнгийн тайлан, (мянган төгрөг) .....	40
Хүснэгт 10. Мөнгөн гүйлгээний тайлан, (мянган төгрөг) .....	42
Хүснэгт 11. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд.....	42
Хүснэгт 12. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд .....	43
Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл .....	49
Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл .....	49
Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн.....	52
Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн санхүүгийн тайлан, тэнцэл.....	57
Хүснэгт 17. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр.....	57
Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл .....	58
Хүснэгт 19. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал .....	59
Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл .....	60
Хүснэгт 21. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл.....	63
Хүснэгт 22. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр .....	72
Хүснэгт 23. Төлбөрийн хуваарь ба төлбөр тооцох аргачлал .....	73
Хүснэгт 24. Төлбөрийн график, сая төгрөгөөр .....	76
Хүснэгт 25. Хөрөнгийн багцын үзүүлэлтүүдийн хураангуй.....	77
Хүснэгт 26. Хуулийн шаардлагад нийцэж буй байдал.....	77
Хүснэгт 27. Зээлдэгч ба зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур.....	78
Хүснэгт 28. Хөрөнгийн зээлийн багцын шинжилгээний хураангуй үр дүн .....	79
Хүснэгт 29. Зээлийн багцын дүн, анх зээл олгосон ангилаар.....	80
Хүснэгт 30. Зээлийн багцын дүн, зээлийн үлдэгдлээр .....	81
Хүснэгт 31. Хөрөнгийн зээлийн багц, анх олгогдсон хугацааны ангилаар .....	82
Хүснэгт 32. Хөрөнгийн зээлийн багц, үлдэгдэл хугацааны ангилаар.....	82
Хүснэгт 33. Хөрөнгийн багц дахь зээлийг анх олгосон огноо, улирлаар.....	83
Хүснэгт 34.. Хөрөнгийн багц дахь зээлийн үлдэгдэл хугацаа, улирлаар .....	84
Хүснэгт 35. Зээлийн багц, хүүгийн түвшнээр .....	85
Хүснэгт 36. Зээл ба барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа .....	85
Хүснэгт 37. Учирч болзошгүй эрсдэлүүд.....	91
Хүснэгт 38. Учирч болзошгүй эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө.....	92
Хүснэгт 39. Үнэт цаас гаргагчтай холбоотой дүрэм, журмууд.....	99

### Схем

Схем 1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас үүсгэх процесс .....	25
Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт .....	29
Схем 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн хувь эзэмшлийн бүтэц .....	30
Схем 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц .....	46
Схем 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлууд .....	50
Схем 6. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал .....	68





Үнэт цаасны танилцуулга



Схем 7. Сул чөлөөтэй хөрөнгийг байршуулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслүүд.....	75
Схем 8. Төлбөрийн дараалал.....	75
Схем 9. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах хэлбэрүүд.....	86
Схем 10. Модулийн үндсэн бизнес процесс.....	88
Схем 11. Татан буугдах нөхцөл.....	90
Схем 12. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны явцад учир болзошгүй эрсдэлүүд.....	91
Схем 13. Анхдагч зах зээлийн арилжааны үйл явц .....	102





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

**БҮРТГЭВ-02**

Үнэт цаасны танилцуулга 20  
өдөр

БҮРТГЭВ  
№ 11

БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11-ний өдөр

№ 24/272/01

Улаанбаатар хот

### Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.5 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11-р зүйлийн 11.1 дахь хэсэг, 12-р зүйлийн 12.2, 12.11.2 дахь хэсэг, “Бичил Эй Би Эс лоялти ТЗК” ХХК (РД:8419868) (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дахь хэсийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

- “Бичил Эй Би Эс лоялти ТЗК” ХХК нь 20,000,000,000 (хорин түрбум) төгрөг хүртэлх нийт дүнгэй, яг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үн бүхий нийт 200,000 (хоёр зуун мянга) ширээг хүргэлж хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирисээр дамжуулан нийтэд санал болгон гаргасугай.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны срөнхий нөхчлийг тогтоолын Хавсралт 1-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуурыг тогтоолын Хавсралт 2-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шалгуурыг тогтоолын Хавсралт 3-р тус тус баталсугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Н.Гантулга)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГАЮУЛТИ  
ТЗК ХХК



Н.ГАНТУЛГА



2024 -03- 25

БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

2024-03-20  
БҮРТГЭВ  
№ 01

"Бичил Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн  
Талоогол усирэхэд зөвлөлийн 2024 оны 03 сарын 10-ны  
өдрийн 24, 2024 тутамд талооголыг хөгжлийн  
тийн



“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК-ИЙН  
ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Үнэт цаасны төрөл	Автомашины фидуши бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан батаягаат үнэт цаас
Үнэт цаасны артикулов эрхийн байгууллага	Монголын хөрөнгийн бирж
Үнэт цаасны нэр	Бичил З ХБҮЦ
Үнэт цаасны тоо ширхэг	200,000 (хоёр зуун минга) ширхэг хүргэх
Үнэт цаасны нийгмийн исрэлсэн үзүүлэлт	100,000 (нэг зуун минга) төгрөг
ХБҮЦ-аар татан төвлөрүүлэх хөрөнгийн дун	20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг хүргэх
Үнэт цаас гаргахаар төлөвлөж буй хугацаа	2024.02 сар
Үнэт цаасны хүү, хувь хэмжээ: /нисийн/ худалдаа	18.5%
Үнэт цаасны хугацаа: /нийт хугацаа/ худалдаа	24 сар
Үнэт цаасны хүүгийн төрөл	Тогтолцоол
Үнэт цаасны хүү тооцох суурь хувог	365
Үнэт цаасны хүү төхөөх хугацаа: /давтамж/	Улаанбаатар хотын тутамд
Үнэт цаасны үндсэв төлбөр төлгөх хугацаа: /давтамж/	Хагас жил тутамд
Үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоо:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Үнэт цаасны заршуулалт:	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багшыг худалдан авах санхүүжилт
Барьцаа:	Автомашины фидуши бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс





МОНГОЛЫН ХАРДЫГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024-03-25

БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

2024-03-26  
Од. Улаанбаатар хот

ҮРГГЭВ  
№ 01

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК-ИЙН  
Гадаадын уснырхэх зорилжийн 2024 оны 03 сарын 17-ний  
өврийн 29/2024 тоот толгойн үзүүлэлт №2

“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК-ИЙН  
ЗЭСЛИЙН ХӨРӨНГӨД ТАВИГДАХ ХУУЛИЙН ШАЛГУУР

1.	Зээлийн хоронго нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйшлүүлэгчийн бүрэн өмчтэд байх багаад анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
2.	Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйштэгч)-ийн хувьд хуульд шийцсэн, хүчин төгөлдөр, завал билэгдэх үүрэг үүсгэх багаад шандлагчтай тохиоддолд уг зээлийг фидуши/барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлж боломжтой байх;
3.	Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйшлүүлэгч болон зээлдэгчийн хоронд байгуулсан фидушийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйштэгч)-ийн хувьд хуульд шияцсан, хүчин төгөлдөр, завал билэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиоддолд анхны үүрэг гүйшлүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
4.	Зээл нь Анхны үүрэг гүйшлүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидушийн гэрээний зүйлийн хамтвар гуравдагч этгээдэд шияжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;
5.	Анхны үүрэг гүйшлүүлэгчид байгаа мэдээлээр, тасалбар болгох аднийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйштэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцэлтээ татгалзах, харишсан суутгал хийх замаар үүргийт дуусгавар болгох, серег нэхэмжилэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой холцийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлж хүснэг зориг нийтийнээгүй байх;
6.	Фидушийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйшлүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйштэглийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйшлүүлэгчийн зэмшил, хадгалаалтад байх.

—oOo—





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

**БҮРТГЭВ-02**

Үнэт цаасны танилцуулга

СЗХ

о. 2024. сар. 20. 2024

БҮРТГЭВ

No. 01

"Бичил Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-НИЙ  
Татоотын удирдаках шийлжлийн 2024 оны 01 сарын 17-ны  
одрийн 24/25 зурагт тохиогийн хөгжлийн түүрээ



**"БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК" ХХК-НИЙ  
ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨД ТАВИГДАХ САНХҮҮГИЙН ШАЛУУР**

1.	Санхүүгийн зохицуулах хороолын күргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь тээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцж байх;
2.	Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх тээл байх;
3.	Зээлийн эргэн төлөлтийн хуваварт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (толж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эзжэст бүрэн төлөгдж дуусахаар байх;
4.	Фидуцийн гэрээний зүйл нь тээврийн хэрэгслийн давтгалд давтагдсан байх, давттал нь хүчин төгөлдөр байх;
5.	Тасалбар болгосон одрийн байдлаар зээл нь хэвийн төвлөлтэй байх;
6.	Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Аянхы үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлэгч стандартын дутуугүй шалтуур хяягасан байх;
7.	Зээл олгосон одрийн байдлаар зээлдэгчийн ор орлогын харьцаа (ЗҮХ) 80%-с хэтрэхгүй байх. ЗҮХ = (Тасалбар болгох одрийн байдлаарх үндсэн зээлийн ердийн үлдэгээл ) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнслээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнслээ )
8.	Фидуцийн зүйльийн ашиглах/ашигласан хугацааны талаар иххын үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цас гаргагчийн тогтоосон шалтуур хяягасан байх;
9.	Үндсэн зээлдэгчийн орлого дангаср ӨӨХ хангахгүй байгаа тохиолдолд хамгран үүрэг гүйцэтгэгчийн орлогыг судална. /Орлого нотлох баримт авна/ Орлого нотлох баримт: Сүүлийн 6 сарын дансны хуултаа эсвэл НДШ давлагдаа

—00—





2024 -03 - 25

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

2024.03.20  
пн сар өдөр


БҮРТГЭВ  
№ 31

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгож байна. Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх) -иас нэг бүр нь 100,000.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000.0 ширхэг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК нь энэхүү 20,000,000,000.0 төгрөг хүртэлх үнийн дун бүхий үнэт цаасыг гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Бичил глобус финанс ББСБ ХХК (цаашид Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эсхүл Үүсгэн байгуулагч гэх)-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийг багц болгон шилжүүлэн худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд бүрэн зарцуулна. Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй.

**ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХАРИУЦАХГҮЙ! БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно. Энэхүү Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК болон Андеррайтер Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна улс



5183855  
021031195 CTC2420 10



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

БҮРТГЭВР №3

Анхдагч зах зээл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч

Баталгаат үнэт цаас

Бирж эсхүл МХБ

Зээл

Зээлдэгч

Зээлийн баримт бичгүүд

Зээлийн гэрээ

Зээлийн дансны бүртгэл

Зээлийн эргэн төлөлт

МУЦАЭХ

Төлбөр цуглуулах данс

Үйлчилгээ үзүүлэгч

Үнэт цаас гаргагч

Үнэт цаас эзэмшигч

Үнэт цаасны төлбөр

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Хороо эсхүл СЗХ

Хөрөнгийн багц эсхүл  
Зээлийн багц

Хөрөнгийн багцын эсхүл  
Зээлийн багцын эргэн төлөлт

Үнэт цаасны танилцуулга

001 бар 20 өдөр  
БҮРТГЭВР №31

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Анх удаа олон нийтэд үнэт цаасыг худалдаж буй үйл ажиллагаа

Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанийд шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий бүхий хуулийн этгээд буюу Бичил глобус финанс ББСБ ХХК

Үнэт цаас гаргагчийн арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг ойлгоно.

Монголын хөрөнгийн бирж

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Зээлдэгчид зээлийн гэрээний дагуу олгож буй зээл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу хүүгийн хамт эргүүлэн төлөх төлбөрийн үүрэг хүлээсэн этгээд

ББСБ-аас зээлдэгчид олгосон зээлийн гэрээ, барьцааны (фидуцийн) гэрээ болон зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүд

Зээлдэгч болон Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээ

Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээлэл

ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөр

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо

Зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг хүлээн авах зорилгоор банканд тусгайллан нээсэн тусгай зориулалтын компанийн данс

Үнэт цаас гаргагчтай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлтийн холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх үйлчилгээг үзүүлж буй этгээд

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож буй тусгай зориулалтын компани буюу Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК

ТЗК-ийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авч, эзэмшиж буй этгээд

Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв буюу УЦТХТ

Санхүүгийн зохицуулах хороо

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хооронд "Хөрөнгө худалдах, худалдан авах" гэрээний тусгай нөхцөлийн 1 дүгээр зүйлд тодорхойлогдсон, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүд

ХБҮЦ-ны хөрөнгийн багцад багтсан Зээлийн төлөлт буюу Зээлдэгчээс Зээлийн гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх мөнгөн төлбөр

БИЧИЛ  
ЭЙ БИ ЭС  
ЛОЯЛТИ  
ТЗК  
ХХК  
Монгол Улс  
9419868  
10462

ӨЛЗИЙ ЭНД КО  
+ КАПИТАЛ УҮСК  
ХХК  
Монгол Улс  
5183858  
9021031196 СТС2420  
БИЧИЛ  
ЭЙ БИ ЭС  
ЛОЯЛТИ  
ТЗК  
ХХК

2024 -03- 25



Хөрөнгийн жагсаалт

Хөрөнгө

Хөрөнгө итгэмжлэн удирдагч

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх

Шаардлага хангахгүй хөрөнгө

Шалгуур үзүүлэлт

Үнэт цаасны танилцуулга

076 06 20 өдөр

БҮРГЭВ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хороондын "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний Хавсралт 1-д заасан, худалдаж байгаа автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн жагсаалт

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1-д заасан үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх

Тусгай зориулалтын компанийтай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд

Хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас

Зээлдэгч сар тутам зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хэсэгчлэн, эсхүл бүрэн төлөх тохиолдол

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хороондын "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ", "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д тодорхойлсон хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/01 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүд




МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА  
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга



Үнэт цаас гаргагч	Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Бичил глобус финанс ББСБ ХХК
Үнэт цаасны төрөл	Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэр	Бичил З ХБҮЦ
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000.0 (нэг зуун мянга) төгрөг
Үнэт цаасны тоо ширхэг	200,000.0 (хоёр зуун мянга) ширхэг хүртэлх
Үнэт цаасны нийт үнийн дүн	20,000,000,000.0 (хорин тэрбум) төгрөг хүртэлх
Үнэт цаасны хугацаа	24 (хорин дөрөв) сар
Үнэт цаасны хүү	18.5 (арван найм аравны тав) хувь
Үнэт цаасны хүүгийн төлөлт	Улирал тутамд
Үнэт цаасны хүү тооцох суурь хоног	365 (гурван зуун жаран тав) хоног
Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт	Хөрөнгө оруулагчид төлөх үндсэн төлбөрийг хагас жил тутамд буюу 4 тэнцүү хувааж төлөх ба Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 сар тутмын мөн өдөр төлнө. (үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.)
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн орлого
Үнэт цаасны хүүгийн орлогод ногдох татвар	5.0 (тав) хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд арилжаална.
Хөрөнгийн багцын дүн	25,678,165,277.1 (хорин таван тэрбум зургаан зуун далан найман сая нэг зуун жаран таван мянга хоёр зуун далан долоо) төгрөг (арван) мөнгө
Зээлийн тоо	1,484
Зээлдэгчдийн тоо	1,484
Барьцаа	Автомашины фидуци бүхий зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс
Зээлийн чанар	100 хувь хэвийн
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох Бичил глобус финанс ББСБ ХХК-иас автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцыг худалдан авахад зарцуулах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу зээл олгох, үйл ажиллагаагааг санхүүжилтийг татахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс гаргахгүй болно.)

УДААНЫААТАР ХОТ

БИЧИЛ  
ЭЙ БИ ЭС  
ЛЮАЛТИ  
ТЗК ХХК  
8419868  
1410482

ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УҮСК  
ХХК  
5183855  
9021031195 СТС2420 13



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

БҮРГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга 20  
өдөр

СХ  
БҮРГЭВ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч



**БИЧИЛ ГЛОБУС**

БААНЫН САЛБАРЫН ТАЙВААНЫ НАМ

#### Бичил глобус финанс ББСБ ХХК

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол (14180), Ногоон нуурын гудамж, Прован оффис, 705 тоот
- (+976) 7000-2020
- [www.bichilglobus.mn](http://www.bichilglobus.mn)
- [info@bichilglobus.mn](mailto:info@bichilglobus.mn)

Үндсэн Андеррайтер



#### Өлзий энд Ко капитал УЦК ХХК

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 тоот
- (+976) 7777-6377
- [www.ucc.mn](http://www.ucc.mn)
- [info@ucc.mn](mailto:info@ucc.mn)

Зээлийн санхүүгийн шинжилгээ гаргагч



#### Си Пи Ти Эй Аудит ХХК

- Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв, 5 давхар, 501 тоот
- (+976) 7723-3030
- [www.cptaaudit.mn](http://www.cptaaudit.mn)
- [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Хуулийн фирм



#### Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХК

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 13 давхар, 1301 тоот
- (+11) 330048
- [www.mdskhanlex.com](http://www.mdskhanlex.com)
- [info@mdsa.mn](mailto:info@mdsa.mn)

Хөрөнгө итгэмжлэн удирдагч фирм



#### Юү Эй Эф Ассет Менежмент ХХК

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1004-1007 тоот
- (+976) 7012-2346
- [www.uaf.mn](http://www.uaf.mn)
- [info@uaf.mn](mailto:info@uaf.mn)

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААС САНАЛ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ ХООРОНДОО БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АНХНЫ ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ/ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС  
ГАРГАХААС БУСДААР АЛИВАА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БОЛОН БИЗНЕСИЙН ХОЛБОО  
ХАМААРАЛГҮЙ БӨГӨӨД ХОЛБООТОЙ ЭТГЭЭДҮҮД БИШ БОЛНО.




АТА11232-4 8419868  
8024010482



5183856  
5021031195 CTC2420  
14





ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:



АНДЕРРАЙТЕР:



# НЭГ. Хөрөнгө оруулалтын орчин

## БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБҮМ





2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга




## 1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Монгол Улсын бодит эдийн засаг 2023 оны эхний гурван улиралд 6.9 хувиар өсжээ. Энэхүү эдийн засгийн өсөлтийг коронавируст цар тахал (Ковид-19)-ын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 1.3 пунктээр өндөр үзүүлэлт болж байна. Дэлхийн банкны 10 дугаар сард шинэчилсэн Монгол Улсын эдийн засгийн 2023 оны төсөөлөлтэй харьцуулахад бодит эдийн засаг 1.8 пунктээр өндөр өсөлттэй байна.

График 1. Монгол Улсын Бодит ДНБ-ийн өсөлт, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт Олон Улсын банк, санхүүгийн байгууллагаас гаргасан төсөөллөөр дунджаар 5.7 хувь өсөх төлөвтэй байна. Харин 2023 онд БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдэж бараа, таваарын нийлүүлэлт сайжирсан болон ковидын дараах худалдаа, үйлчилгээний салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтөнд гол түлхэц үзүүлсэн юм.

Тухайлбал, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.3 хувь өссөн бол нүүрсний экспортын биет хэмжээ 2.6 дахин, нүүрсний борлуулалтын орлого 44.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. БНХАУ ба Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал

Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийн таамаглал	БНХАУ-ын 2024 оны эдийн засгийн өсөлтийн таамаглал
Монголбанк	6.2%
Азийн хөгжлийн банк	5.9%
Дэлхийн банк	6.2%
ОУВС	4.5%
Дундаж	5.7%
	Дундаж
	4.5%

Эх сурвалж: Банк, санхүүгийн байгууллагын вэбсайт

Иймд 2024 оны Монгол Улсын эдийн засгийн өсөлт БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, түүхий эдийн эрэлтээс шууд хамаарахаар байгаа юм. 2023 онд БНХАУ-ын эдийн засаг үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, дотоодын өрийн дарамт зэргээс шалтгаалан урт хугацааны зорилтолт түвшин 5.0 хувиас доогуур буюу 4.5 хувийн өсөлттэй байна гэж Олон Улсын шинжээчид харж байна.

5183855  
2024031196 CTC2420

16



2024 -03- 25

БНХАУ-ЫН бодит ДНБ-ийн өсөлт 2022 онд 3.0 хувь байсан талаар тус улсын Үндэсний статистикийн товчооноос мэдээлсэн. Энэхүү өсөлт нь АНУ, Япон, Герман гэх мэт хөгжингүй орнуудын 2022 оны эдийн засгийн өсөлттэй харьцуулахад харьцангуй өндөр өсөлт юм.


Үнэт цаасны танилцуулга

2024 -03- 20  
ГЭР

## ИНФЛЯЦ БА МӨНГӨНИЙ БОДЛОГО

2022 оны 01 дүгээр сард Төв банкны бодлогын хүү 6.0 хувьд байсан бол 2022 онд нийт 5 удаа бодлогын хүүг өсгөж 13.0 хувьд хүргээд байна. Монголбанкны зүгээс өнгөрсөн онд мөнгөний хатуу бодлогыг туштай баримталсан нь инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сард 7.9 хувьд хүрч, нэг оронтой тоонд хүрэхэд хамгийн чухал, үр дүнтэй бодлогын хэрэгсэл болсон юм.

График 2. Инфляц ба бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк

Мөн АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас 2022 онд бодлогын хүүгээ 0.25 хувиас нэмэгдүүлж 4.5 хувьд хүргэсэн нь бусад улс орнууд амдоллартай харьцуулсан үндэсний валютын ханшаа мөнгөний бодлогын хэрэгслээр дамжуулан тогтворжуулах арга хэмжээ авахад хүргэжээ.

График 3. 2024 оны инфляцын төсөөлөл



Монголбанкны 2023 оны 12 дугаар сарын инфляцын тайланд дурдсанаар тээврийн зардлууд бууран, гадаад шалтгаантай үнийн дарамт буурч байна гэжээ. 2024-2025 онд Төв банкны зүгээс инфляцын түвшин 8.7 ба 7.7 болж аажмаар саарах хүлээлттэй байна. Энэхүү

хүлээлтэнд цаашид төгрөгийн ханш тогтворжиж, худалдааны түнш орнуудын үнийн өсөлт саарч, тээврийн эргэлт хурдсан зардал буурах нь голлон нөлөөлөх төлөвтэй байна.

АТА 112324 8419868  
АТА 112324 840482

Оюунжилж  
Оюунжилж  
17  
5183868  
9021031195 СТС2420




2024-08-25

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

БҮРТГЭВ-02

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оны эцсээс 26.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлт 2019 оноос хойш 2023 он хүртэл жилд дунджаар 15.5 хувийн өсөлттэй байна. 2020 онд мөнгөний нийлүүлэлт 16.1 хувиар өссөн нь коронавируст цар тахлын үед эрэлтийг дэмжих зорилгоор Монголбанкнаас мөнгөний зөвлөн бодлого хэрэгжүүлж байсантай холбоотой юм.

График 4. Мөнгөний нийлүүлэлт ба заавал байлгах нөөцийн хувь




Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэмэгдэж, банкны системийн нийт зээлийн өсөлт сүүлийн саруудад алгуур сэргэж буйг Төв банкны 2023 оны 12 дугаар сарын тайландаа онцолжээ. Цаашид төлбөрийн тэнцэл ашигтай гарч байгаа, өөрийн хөрөнгийн өсөлттэй холбоотойгоор банкны зээл олгох боломжтой төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэн, уул уурхайн секторын орлого нэмэгдэж байгаа зэрэг нь ойрын хугацаанд мөнгөний нийлүүлэлтийн хурд хадгалагдах төлөв харуулж байна.

График 5. Зээлийн өрийн үлдэгдэл, их наяд төгрөг



2023 оны 3 дугаар улиралд банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 26.1 их наяд төгрөг байгаа бол банк бус санхүүгийн салбарын зээл 3.4 их наяд төгрөг буюу банкны салбарын нийт зээлийн 13.0 хувтай дүйцэж байна. Банкны салбарын



Үнэт цаасны танилцуулга

2024-08-25 № 01  
БҮРТГЭВ  
№ 01



ӨЛЗИЙН ҮЛДЭГДЭЛ  
УЛААНбаатар хот

КАПИТАЛ УҮК

ХХК

6183668

901031195 СТС2420



2024-03-25

Үнэт цаасны танилцуулга 2024 сар өдөр

зээлийн өрийн үлдэгдлийн жилийн дундаж өсөлт (CAGR) 9.1 хувь байгаа бол банк бус санхүүгийн салбарын зээлийн жилийн дундаж өсөлт (CAGR) 33.1 хувь байна.

2022 онд бодлогын хүүгийн өсөлтийн нөлөөгөөр банкуудын шинээр татсан хадгаламжийн хүү 2023 оны 11 дүгээр сард 11.6 хувь байгаа бол нийт зээлийн үлдэгдэл тооцсон зээлийн жигнэсэн дундаж хүү 17.0 хувь байна. 2021 онд Монголбанкнаас бодлогын хүүг 6.0 хувь хүртэл буулгаж, харилцах болон хугацаагүй хадгаламжид хуримтлагдах хүүг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал тооцохгүй байх хуулийн зохицуулалт хэрэгжиж байсан. Энэ нь 2021 онд зах зээл дээрх хүүгийн ерөнхий түвшин буурах нөхцөл болсон юм.

График 6. Зээлийн хүү ба хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк, YCX

## ГАДААД ХУДАЛДАА БА ВАЛЮТЫН ХАНШ

Монгол Улсын экспортын орлого 2023 оны эхний 11 сард өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулахад 10.1 хувиар өссөн байна. Энэхүү экспортын борлуулалтын орлогын дүн Коронавируст халдвартын цар тахлын өмнөх 2019 оны экспортын орлоготой харьцуулахад 81.2 хувиар өндөр үзүүлэлт юм.

График 7. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд, сая ам.доллар





2024-03-25

## Үнэт цаасны танилцуулга

33

БҮРТГЭВ  
Ы НИЙТ  
№ 01


2023 оны 11 дугээр сарын байдааар Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 22.1 тэрбум ам.долларт хүрчээ. Тус хугацаанд гадаад худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан бөгөөд цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 3.6 дахин өссөн эерэг үзүүлэлт болж байна. 2023 оны эхний арван нэгэн сард гадаад худалдааны сектор ашигтай гараад нүүрсний экспортын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 дахин өсөж, орлогын хэмжээ нь 7.9 тэрбум ам.долларт хурсэн нь нөлөөлсөн.

График 8. Ам.долларын ханшийн өөрчлөлт



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2022 оны жилийн эцэст 3,444.6 төгрөгт хүрсэн бөгөөд тус онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 20.9 хувиар суларчээ. 2019 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3.4 хувиар унасан бол 2020 онд 4.2 хувь, 2021 онд жилийн эхний ханш сүүлийн ханшаас өөрчлөгдөөгүй байсан. 2023 оны жилийн эцэст ам.долларын төгрөгтэй харьцах ханш 3,410.6 төгрөг байв.

График 9. Гадаад валютын улсын нөөц (ГВУН), сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын нээц 2022 оны 01 дүгээр улирлаас эхлэн хумигдаж эхэлсэн нь хил, гаалийн хорио цуцлагдаж гадаад руу хийх бараа, үйлчилгээний төлбөр төлөлт ихэссэн, 1.5 тэрбум ам.долларын Чингис бондын үлдэгдэл төлөлт хийгдсэн нь ихээхэн нөлөөлжээ. Гэхдээ 2022 оны 3 дугаар улирлаас ГВУН тогтмол нэмэгдэж 2023 оны эцэст 4,918.3 сая ам.долларт хурсан байна.

DC  
174  
XX

улирлаас эхлэн  
УЛААНБААТАР ХОТ  
руу хийх бараа,  
Чингис бондын  
ФИЗИК  
дугаар улирлас  
эн байнахи.



2024-03-25

УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга


2024 дэг 26-дөр

ҮҮРГГЭВ

No. 01

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусlamжийн дун 2023 оны эцэст 24.3 их наяд төгрөг байгаа бол нийт зарлага, цэвэр зээлийн дун 22.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 4.3 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд коронавируст цар тахлын эсрэг Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь төсвийн зардлыг 2019 онтой харьцуулахад 31.6 хувиар буюу 2.6 орчим их наяд төгрөгөөр өсгөжээ. 2023 оны эцэст төсвийн тэнцэл 1.8 их наяд орчим төгрөгийн ашигтай гарчээ.

График 10. Монгол Улсын төсвийн орлого ба зарлага, (их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Ажилгүйдлийн түвшинг Үндэсний статистикийн хорооноос зарласан улирлын мэдээллээс харахад 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 5.2 хувьд хүрсэн байна. 2023 онд ажилгүйдлийн түвшин ийнхүү буурч байгаа нь цар тахлын дараа дотоодын эдийн засаг аажмаар сэргэж буй эерэг дохио болж байна.

График 11. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 1,269.2 мянгад хүрсэн ба 2021 оноос 131.5 мянган хүнээр нэмэгдсэн нь дотоодын хөл хорионоос гарсан иргэдийн ажил эрхлэх сонирхол нэмэгдсэн, ажлын байрны нийтийн эсэж байгаа нь нөлөөлжээ.





## 1.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

График 12. Үнэт цаасны гүйлгээ (сая төгрөг) ба ТОП-20 индекс



дундаж үнэт цаасны гүйлгээний дүн 13.4 тэрбум төгрөг, 2021 онд 97.2 тэрбум төгрөг, 2022 онд 45.9 тэрбум төгрөг, 2023 онд 60.4 тэрбум төгрөг болжээ.

График 13. Зах зээлийн үнэлгээ, (их наяд төгрөг) ба ДНБ-тэй харьцуулсан харьцаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 онд Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд тухайн оны нэрлэсэн ДНБ-тэй харьцуулсан харьцаа 12.6 хувь буюу хөрөнгийн зах зээл нийт эдийн засгийн 12.6 хувьтай дүйцэж байгааг харуулж байна. 2021 онд Төв банкнаас мөнгөний зөвлөн бодлого барьсан ба Монгол Улсын Засгийн газраас иргэдэд нэг удаа олгосон тэтгэмж, бусад халамжийн бодлогууд нь хөрөнгийн зах зээл рүү орох мөнгөн ургсалыг нэмэгдүүлжээ. 2023 оны 12 дугаар сарын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 68.0 хувиар өсжээ,






### 1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

**БҮРТГЭВ-02**

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2023 оны 3 дугаар улиралд 4.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 20.7 хувиар буюу 730.4 орчим тэрбум төгрөгөөр өсжээ. Нийт хөшүүргийн харьцаа 1.5 буюу нийт өр төлбөр 39.1 хувийг эзэлж байна. 2018 оноос хойш хөшүүргийн харьцаа тогтмол өсөж байгаа нь итгэлцэл, өрийн бичиг, банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн санхүүжилт нэмэгдэж байгаа нь нөлөөлжээ.

График 14. Нийт хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо

Салбарын нийт өр төлбөрийн дүн 2018 оноос хойш жилд дунджаар 44.3 хувиар өсжээ байна. Банк бус санхүүгийн салбарын нийт өр төлбөрийн бүтэц 2023 оны 3 дугаар улиралд итгэлцлийн үйлчилгээний өглөг 31.1 хувь буюу 519.3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оноос 36.3 хувиар өсжээ.

График 15. Нийт өр төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Ундэсний статистикийн хороо


Харин бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 470.6 тэрбум төгрөг буюу нийт өр төлбөрт 28.2 хувийг эзэлж байна. Өрийн хэрэгсэл болон бусад өр төлбөрийн дүн 677.8 тэрбум төгрөг буюу нийт өрийн эх үүсвэрт 40.6 хувийг тус тус эзэлж байна.





Нийт хөрөнгөд эзлэх нийт зээлийн багцын дүн 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оноос 24.1 хувиар өсөж 3,378.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн хувь 2023 оны 3 дугаар улиралд 7.5 хувьд хүрч өнгөрсөн оноос 0.1 пунктээр нэмэгдсэн. Цар тахлын эхэн үед буюу 2020 онд чанаргүй зээлийн хувь харьцангуй тогтвортой байх хандлага үзүүлж байна.


График 16. Зээлийн багц (тэрбум төгрөг) ба чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Банк бус санхүүгийн салбарын нийт орлого 2023 оны эхний гурван улиралд 814.6 тэрбум төгрөг, нийт зарлага 512.2 тэрбум төгрөг байсан бөгөөд цэвэр ашигийн дүн 302.4 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны жилийн үр дүнтэй харьцуулахад 11.0 орчим тэрбум төгрөгөөр бага байна. Нийт орлого 2023 оны эхний 9 сард 814.6 тэрбум төгрөгт хүрсэн ба цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 2.3 дахин өссөн байна.

График 17. Банк бус санхүүгийн салбарын нийт орлого, нийт зарлага ба цэвэр ашиг (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо





Үнэт цаасны танилцуулга



## 1.4. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэдэг нь зээл, түрээс болон санхүүгийн түрээсийн гэрээ, моргейжийн зээл, авлага зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой санхүүгийн хэрэгсэл буюу Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна.

Схем 1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас үүсгэх процесс



### ХӨРВӨХ ЧАДВАР САЙН

Ирээдүйд мөнгөн урсгал бий болгох чадвартай зээлийн багцыг үнэт цаасанд хөрвүүлснээр тухайн үнэт цаасжуулж буй хөрөнгө болох зээлийн багцын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, улмаар хөрөнгө оруулагч наарт арилжаалах боломжтой, илүү хөрвөх чадвар сайн, үнэт цаас хэлбэрийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг санал болгох нөхцөл бүрддэг юм. Нөгөө талаас анхны үүрэг гүйцэтгүүлэгч зээлийн багцаа Тусгай зориулалтын компанийд худалдсанаар санхүүгийн хөрвөх чадвараа нэмэгдүүлдэг давуу талтай.

### ЭРСДЭЛ БАГА

Үнэт цаасжуулж буй хөрөнгийг тусгай зориулалтын компаний руу шилжүүлснээр тухайн хөрөнгийн үнэ цэнэ анхны үүрэг гүйцэтгүүлэгч компанийн үйл ажиллагаанаас хамааран буурах, эргэн төлөлт тасалдах гэх мэт эрсдэлээс тусгаарлагдаж, хөрөнгө оруулагч нарыг хамгаалах боломжтой болдог. Ийнхүү тусгай зориулалтын компаний нь үнэт цаасжуулсан хөрөнгийг бүрэн өөр дээрээ шилжүүлж авснаар тухайн хөрөнгөөс бий болсон мөнгөн урсгалыг эргэн төлөлт хэлбэрээр үнэт цаас эзэмшигч наарт олгох, хөрөнгийг удирдах үндсэн чиг үүрэгтэй ажиллах боломжийг олгодог ба тухайн хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлээс салангид авч үзэх боломжтой болдог юм.

### ТОГТМОЛ ӨГӨӨЖК

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь компанийн бонд, банкны хугацаатай хадгаламж, Засгийн газрын бондтой төстэй бөгөөд хөрөнгө оруулагч наарт эрсдэл багатай, баталгаат, тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хөрөнгө оруулагч наарт үндсэн болон хүүгийн төлбөрийг найдвартай эргэн төлөх зорилготойгоор үнэт цаасжуулсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гэдгээрээ онцлогтой.



МОНГОЛЫН ЭРГОНДЫН БАРДЫК  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2024-03-25  
БАРГАЗИЙН 02

СЭХ  
БАРГАЗИЙН 02  
БАРГАЗ  
М.Н.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:




# ХОЁР. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тухай

## БИЧИЛ 3.0


ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ





Үнэт цаасны танилцуулга



## 21. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бичил глобус финанс ББСБ нь анх 2008 онд 3 хүний бүрэлдэхүүнтэй, шуурхай бичил зээлийн үйлчилгээгээр бизнесийн гараагаа эхэлсэн. 2011 онд анхны хөрөнгө оруулалт болох 1.0 сая ам.долларыг Австрали улсаас татаж байсан туршлагатай ба 2013 онд Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан. 2023 оны байдлаар буюу анх үүсгэн байгуулагдсанаас хойш 15 жилийн дараа Бичил глобус финанс ББСБ нь Улаанбаатар хотод 15 салбар, орон нутагт 1 салбар буюу нийт 16 салбар нэгж, 15,000 гаруй харилцагчидтай болсон ба 70 гаруй чадварлаг мэргэжилтнээр дамжуулан 81.5 тэрбум төгрөгийн нийт зээлийн багцтайгаар, бичил санхүүгийн зах зээлд үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл


Компанийн нэр	Бичил глобус финанс ББСБ
Хариуцлагын хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Үүсгэн байгуулагдсан огноо	2013.07.17
Улсын бүртгэлийн дугаар	9015002106
Регистрийн дугаар	5729718
Гүйцэтгэх захирал	Самдангийн Отгонбат
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>Зээлийн үйл ажиллагаа</li> <li>Факторингийн үйлчилгээ</li> <li>Итгэлцлийн үйлчилгээ</li> </ul>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000,000,000.0 (таван тэрбум) төгрөг
Хувьцааны тоо ширхэг, төрөл	100.0 (нэг зуун) ширхэг, Энгийн хувьцаа
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	50,000,000.0 (тавин сая) төгрөг
Биржид бүртгэлтэй эсэх	Үгүй
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, гудамж, 101 барилгын 705 тоот
Утас	(+976) 7000-2020
Цахим шуудан	<a href="mailto:info@bichilglobus.mn">info@bichilglobus.mn</a>
Цахим хаяг	<a href="http://www.bichilglobus.mn">www.bichilglobus.mn</a>

## БИЧИЛ – ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮГИЙН ЭХЛЭЛ

Монгол Улсын санхүүгийн зах зээлд Бичил глобус финанс ББСБ үүсэн байгуулгахаа болсон шалтгаан нь анх санхүүгийн зах зээл рүү хөл тавих үед Банк, санхүүгийн салбарт бичил зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тун дутмаг байсан бөгөөд санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээ нь тулхүү дунд түвшний, амьжиргааны түвшин сайн, тогтмол орлоготой иргэдэд чиглэж байсан. Хувираадаа

бизнес эрхлэгч иргэд, жижиглэн худалдааны бизнес эрхлэгч нар тухайн үед тогтмол орлогогүй, зээлийн барьцаа хөрөнгөгүй гэх шалтгаанаар арилжааны банкнаас зээл

АТА11230 8419868  
10402



афах шалгуурт тэнцдэггүй, зээл авах боломжгүй байсан юм. Энэхүү санхүүгийн үйлчилгээнд гарсан доголдол, хүртээмжгүй байдлыг арилгах зорилготойгоор анх барьцаагүй зээлийн үйлчилгээг Бичил глобус финанс ББСБ нь иргэдэд олгож эхэлсэн билээ.

## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БИЗНЕСИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Зураг 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бизнесийн үнэт зүйлс



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Хүснэгт 3. Үүсгэн байгуулагч/Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл

№	Тусгай зөвшөөрөл	Олгосон огноо
1	Зээлийн үйл ажиллагаа	2013.10.23
2	Факторингийн үйлчилгээ	2018.09.12
3	Итгэлцлийн үйлчилгээ	2019.12.04

## ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Хүснэгт 4. Компанийн түүх

### 2021-2023 он

- 2023 он: Бичил 2.0 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 20.0 тэрбум төгрөг амжилттай татан төвлөрүүлсэн.
- 2022 он: Бичил Эй Би Актив хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган 10.0 тэрбум төгрөг амжилттай татан төвлөрүүлэв.
- 2021 он: Ти Ди Би секьюритис УЦК ХХК-иар зуучлуулан 10.0 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг амжилттай татан төвлөрүүлсэн.


### 2017-2018 он

- 2017 он: Ниссан цахилгаан автомашиныг Монгол Улсын зах зээл, цаг агаарын нөхцөлд амжилттай туршин, "Эко зээл"-ийг нэвтрүүлсэн анхны санхүүгийн байгууллага болов.

### 2015-2016 он

- 2015 он: Иргэдийнхээ зээлжих боломжийг нэмэгдүүлэхийн тулд СЗХ-той хамтран ажилласны үр дунд шийнэгээлийг 0% болгож хүүг холбогдох журмын дагуу өөрчлөлт оруулав. Үүний үр дунд зээл авах хугацаа дагаад уртассан сайхан мэдээг харилцагч нартаа хүргэв.





- 2012 он: санхүүгийн хүртээмжийг иргэдэд улам ойртуулахын төлөө 2009 оноос хойш 2012 оны байдлаар Улаанбаатар хотод **8 салбар** нэгжтэйгээр иргэдийнхээ тулгамдаж буй асуудалд шийдвэр гаргалтыг улам хурдасгаж ажилласан он жилүүд байв.


**2010-2011 он**

- 2011 он: Австрали улсаас 1.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг татсан. Зах зээл дээр байгаа дундаж хүүг эргэлтийн хөрөнгө оруулалтаар буулгаж, ажиллагсад болон зээлдэгчдийнхээ төлөлт болоод цалингийн асуудал дээр анхаарч ажилласан.

## 2.2. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бичил глобус финанс ББСБ нь компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн эрх барих дээд удирдлагатай. Гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг бөгөөд Санхүү бүртгэлийн газар, Хууль эрх зүйн газар, Хөрөнгө зохицуулалтын газар, Зээлийн газар, Эрсдэлийн удирдлагын газар, Маркетингийн газар, Дотоод аудитын газар, Үйл ажиллагааны газар, Хүний нөөцийн газар, Мэдээлэл технологийн газар гэсэн шинэчилсэн бүтцээр ажиллаж эхлээд байна.

Схем 2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үүсгэн байгуулагчийн мэдээлэл





250


БҮРТГЭВН-02

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт зааснаар "толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1 (хараат компани), 6.3 (охин компани), 6.8 (хараат болон охин компанийн үргэлжилсэн хэлхээ холбоо)-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ" гэж заасан байна. Энэхүү заалтын дагуу "Бичил глобус финанс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болон компанийн нэгдлийн бүтэц нь дараах байдалтай байна.

## Үнэт цаасны танилцуулга

СХ  
ицуулга 2000  
БҮРГЭВ  
“ТӨГЛӨМ”

Схем 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн компанийн хувь эзэмшлийн бүтэц



- (а) С.Отгонбат** нь Бичил глобус ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн 94.4 хувийг эзэмшдэг. **Б.Хүрэлхүү** нь Бичил глобус ХХК-ийн 5.6 хувийг эзэмшдэг юм.

**(б) Бичил Глобус ХХК** Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, бизнесийн болон менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг.

**(в) Бичил глобус финанс ББСБ ХХК** Зээл, факторингийн үйл ажиллагаа болон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллага.

**(г) Эрдэнийн опал ХХК** Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, автомашины засвар үйлчилгээ, авто зогсоол, гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэгч байгууллага.

### **2.3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнээс бүрдсэн байхаар заажээ. Үүний хүрээнд, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн №19/01A/136 тоот шийдвэрээр ТУЗ-ийн 3 ердийн гишүүн болон 2 хараат бус гишүүнийг тус тус томилсон байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг өөрийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжүүлэхийг эрмэлзэж ажиллаж байгаа ба ТУЗ-ийн гишүүд Компанийн засаглалын чиглэлээр сургалтад бурэн хамрагдсан байна.





## Үнэт цаасны танилцуулга



**Хүснэгт 5. Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Төлөөлөн удирдах зөвлөл**

#### Боловсрол

- 2004-2006, МУИС, ХЗС, Хууль зүйн магистр;
  - 1999-2001, МУИС, ХЗС, Эрх зүйн бакалавр;
  - 1992-1996, МУИС, ЭЗС, Эдийн засаг, нягтлан бодогч, бакалавр;
  - 1982-1992, Дархан-Уул, Дархан хот, 15-р сургууль, Бүрэн дунд.

## Ажлын туршлага

- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн дарга;
  - 2012-Одоо, "Эн Си Ди Групп" ХХК, Гүйцэтгэх захирал;
  - 2005-2012, "Номин Реалтор" ХХК, Гүйцэтгэх захирал;
  - 2003-2005, "Номин Холдинг" ХХК, Дотоод аудитын газрын дарга.

## Боловсрол

- 2011-2013, МУИС, Олон Улсын эдийн засгийн харилцааны магистр;
  - 2006-2010, Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;
  - 1992-2002, 12-р сургууль, Бүрэн дунд.

## Ажлын туршлага

- 2013-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захидал;
  - 2017-Одоо, "Бэрс финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захидал;
  - 2008-2009, "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;
  - 2006-2007, "Оргил-Хотхон" ХХК, Гүйцэтгэх захидал.

## Боловсрол

- 2016-2019, Сити их сургууль, Архитектурч, Бакалавр;
  - 2014-2016, Сити их сургууль, Үйлдвэр удирдлагын менежмент, Бакалавр;
  - 2002-2005, ШУТИС, Нефть хийн өрөмдлөг, олборлолтын инженер мэргэжлээр бакалавр;
  - 1992-2002 Дархан-Уул Оюуны ирээдүй цогцолбор, Бүрэн дунд.

### • 1992-2002, дарын түршлэгээ

- 2019-Одоо, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, ТУЗ-ийн гишүүн;
  - 2022-Одоо, “Дархан төгөлдөр” ХХК, Ерөнхий захирал;
  - 2017-Одоо, “Баянтөхөм шандат” ХХК, Зураг төслийн удирдах инженер;
  - 2013-2017, “Ноёдын туурь” ХХК, Зураг төслийн инженер;
  - 2009-2013, “Нью Арен” ХХК, Захирал.

## Боловсрол

- 2002-2006, Их засаг Их сургууль, Эрх зүйч мэргэжлээр бакалавр;
  - 1992-2002, Увс аймаг, Улаангом, 2-р сургууль, Бурэн дунд.

## Ажлын туршлага

- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн;
  - 2021-Одоо, "Баясах трейд" ХХК, Хүний нөөцийн менежер;
  - 2015-2021, "Бэрс финанс ББСБ" ХХК, Хүний нөөцийн менежер;
  - 2009-2015, "Сод Монгол Групп", Хүний нөөцийн менежер;
  - 2007-2009 "Очир угалз содишин" ХХК, Хувьлийн зөвлөх.

- 2007-2008

- 2001-2006, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага, Бакалавр;
  - 1999-2000, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Референт;
  - 1990-1999, Эрдэнэт хот, 5-р сургууль, Бүрэн дунд.

1999-1999 бүрдэ

- 2017-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн;
  - 2017-Одоо, "Бэрс финанс ББСБ" ХХК, Бичиг хэргийн ажилтан;
  - 2013-2016, "Төрийн банк", Захирлын туслах;
  - 2008-2012, "Умбайн шим" ХХК, Менежер;
  - 2007-2008, МУИС-ОАСС, Нарийн бичиг.





Үнэт цаасны танилцуулга  
2024-03-25 20:20  
БҮРТГЭВН

2.4. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ  
УДИРДЛАГЫН БАГ

Хүснэгт 6. Үүсгэн байгуулагч/анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Гүйцэтгэх удирдлагын баг



С.Отгонбат  
Гүйцэтгэх захирал

**Боловсрол**

- 2011-2013, МУИС, Олон Улсын эдийн засгийн харилцааны магистр;
- 2006-2010, Алтай коллеж, Компьютер техникийн бакалавр;
- 1992-2002, 12-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**

- 2013-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн;
- 2017-Одоо, "Бэрс финанс ББСБ" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2008-2009, "Номин Холдинг" ХХК, Ахлах менежер;
- 2006-2007, "Оргил-Хотхон" ХХК, Гүйцэтгэх захирал.



Б.Баярчимэг  
Дэд захирал

**Боловсрол**

- 2019-2021, ХААИС, Бизнесийн удирдлагын магистр;
- 1999-2003, СЭЗИС, Банк санхүүч, бакалавр;
- 1989-1999, 24-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**

- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Дэд захирал;
- 2018-2019, "Голомт банк", Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал;
- 2003-2017, "Төрийн банк", Хяналт шалгалтын газрын захирал.



Б.Даваабат  
Маркетингийн газрын  
захирал

**Боловсрол**

- 2008-2011, СУИС, Соёлын арга зүйч, Бакалавр;
- 2006-2008, Соёлын коллеж, Компьютерийн оператор, тусгай дунд;
- 1996-2006, 13-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**

- 2021-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Бизнес хөгжлийн газрын захирал;
- 2020-2021, "Оранж электроникс" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2016-2021, "Бичил Глобус" ХХК, Маркетингийн менежер;
- 2012-2016, "Креатив пролайн" ХХК, Брэнд менежер, Креатив директор;
- 2011-2012, "Хиймарьпринтинг" ХХК, Ахлах дизайнер.



Я.Ардыяахуу  
Хөрөнгө зохицуулалтын  
газрын захирал

**Боловсрол**

- 1997-1998, Япон Улс, Сайтама их сургууль, Төрийн удирдлагын магистр;
- 1987-1991, МУИС-ЭЗС, Банкны эдийн засгийн бакалавр;
- 1975-1985, Улаанбаатар хотын 1-р сургууль, Бүрэн дунд.

**Ажлын туршлага**

- 2023-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал;
- 2020-2023, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Санхүү бүртгэлийн газрын захирал;
- 2018-2020, "Нэткапитал ББСБ" ХХК, Эрсдэлийн захирал, Дэд захирал;
- 2015-2017, "Глашиер ассет" ХОМК, Гүйцэтгэх захирал;
- 2009-2015, "Хас банк", Хэлтсийн захирал, Газрын захирал;
- 1998-2009, "Худалдаа хөгжлийн банк", Эдийн засагч, Эрсдэлийн шинжээч, Дотоод хяналтын алба, Газрын ахлах;
- 1992-1997, "Зах зээл судлалын хүрээлэн", Судлаач.





Н.Гантулга  
Зээлийн газрын  
захирал

Үнэт цаасны танилцуулга



#### Боловсрол

- 2011-2012, Газарчин их сургууль, Бизнесийн удирдлагын магистр;
- 2001-2005, ШУТИС, Математик загварчлал, Бакалавр;
- 1991-2001, Увс аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.

#### Ажлын туршлага

- 2021-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Зээлийн газрын захирал;
- 2019-2021, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Салбарын удирдлагын мэргэжилтэн;
- 2017-2019, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Салбарын захирал;
- 2015-2017, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Зээлийн менежер;
- 2014-2015, "Аварга Соёо" ХХК, Оффис менежер.

#### Боловсрол

- 2011-2012, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Эконометрикч, Бакалавр;
- 1990-2000, Дорноговь аймаг, Сайншанд сум, 1-р сургууль, Бүрэн дунд.

#### Ажлын туршлага

- 2023-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Үйл ажиллагааны газрын захирал;
- 2020-2023, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Нягтлан бодогч;
- 2017-2020, "Бичил глобус" ХХК, Санхүүгийн мэргэжилтэн;
- 2016-2017, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Хянач нягтлан бодогч;
- 2012-2014, "Чандмань илч" ОНӨААН, Нягтлан бодогч;
- 2010-2012, "Хадгаламж банк", Салбарын эрхлэгч;
- 2005-2009, "Анод банк", Теллер.

#### Боловсрол

- 2018-2020, СЭЗИС, Бизнесийн удирдлагын магистр;
- 2005-2010, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр;
- 1995-2005, Говь-Алтай аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.

#### Ажлын туршлага

- 2019-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Дотоод хяналтын газрын захирал;
- 2019-Одоо, "Добу кредит" ХХК, Гүйцэтгэх захирал;
- 2017-2019, "Бичил глобус" ХХК, Зээлийн хэлтсийн захирал;
- 2011-2017, "Бичил глобус групп" ХХК, Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал;
- 2011, "Бичил глобус" ХХК, Менежер.

#### Боловсрол

- 2006-2010, ИЗОУИС, Бизнесийн эдийн засагч, Бакалавр;
- 1996-2006, Төв аймаг, Борнуур сум, Бүрэн дунд.

#### Ажлын туршлага

- 2023-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Санхүү бүртгэлийн газрын захирал;
- 2020-2023, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Ерөнхий нягтлан бодогч;
- 2015-2020, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Нягтлан бодогч;
- 2014-2015, "Бичил глобус" ХХК, Касс менежер;
- 2012-2014, "Хаан банк", Теллер.



Г.Юмсүрэн  
Дотоод хяналтын газрын  
захирал



Б.Тамир  
Санхүү бүртгэлийн  
газрын захирал





Э.Өнөболд  
Эрсдэлийн удирдлагын  
газрын захирал

#### Боловсрол

- 2006-2010, СЭЗИС, Бизнесийн эдийн засагч, Бакалавр;
  - 1997-2006, Улаанбаатар хот, 1-р сургууль, Бүрэн дунд.
- Ажлын туршлага**
- 2023-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Эрсдэлийн удирдлагын газрын захирал;
  - 2022-2023, "Нэткапитал ББСБ" ХХК, Ахлах эрсдэлийн шинжээч;
  - 2018-2022, "Хаан банк", Зээлийн эрсдэлийн шинжээч;
  - 2015-2018, "Богд банк", Ахлах эрсдэлийн шинжээч;
  - 2013-2015, "Капитал банк", Зах зээлийн эрсдэлийн шинжээч;
  - 2011-2013, "MMREC" ХХК, Судалгааны мэргэжилтэн.

Үнэт цаасны танилцуулга



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

1000 цүнх аян



Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "1000 цүнх" сайн үйлсийн аянд Бичил глобус финанс ББСБ нэгдэж амжилттай оролцож байна.

"Тэрбум мод" хөдөлгөөнд нэгдэв



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд ББСБ-аа төлөөлж өөрсдийн зүгээс Монгол Улсдаа 500,000 мод тарих сайн дурын ажлыг зохион байгуулахаар хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.

Улаан загалмай нийгэмлэгтэй хамтрав



2019 онд Бичил глобус ХХК нь сайн үйлсийн аянаа улам төгөлдөржүүлэх зорилгоор Монголын улаан загалмай нийгэмлэгтэй гэр бүл, хүүхэд залуучуудыг хөгжүүлэх чиглэлд урт хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулав.

Амьдрал бэлэглэе аян



Коронавируст цар тахлын үед 51 бяцхан зүрхний амийг аврахад сайн дураараа Бичил Глобус финанс ББСБ-ын хамт олон цусаа өгч донор өдөрлөгт оролцов.





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

### “Дүдү” хүүхдийн музей



Цар тахалтай хүнд хэцүү үед хүүхэд багачуудын цагаа өнгөрөөх дуртай Дүдү хүүхдийн музейд салбар нэгжүүд болон Төв салбарын ажилчид сайн дураараа Дүдү-г зогсоохгүйн төлөө нэгдэв.

### Хүүхдийн сайн үйлсийн аян



Бичил Глобус ХХК нь 2020 онд Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29-р дунд сургуулийн сургач наарт "Хүмүүнлэгийн танхим" тохижуулж, хүлээлгэн өгөв. Мөн "Хүүхдийн баяр"-ын өдрийг тохиолдуулан гэмтлийн ГСҮТ-ийн Түлэнхий төвд 24 цаг тасралтгүй ашиглагдах хяналтын аппарат бэлэглэв.

### Орон сууцжуулах хөтөлбөр



2009-2018 онд Санхүүгийн нэгдлийнхээ 8 ажилтанд буцалтгүйгээр Орон сууцны урьдчилгаа төлбөр олгосон.

### Үнэт цаасны танилцуулга

#### 1000 мод тарих төсөл



Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч цаг уурын нөхцөл байдалд хамгийн их өртөж байгаа Өвөрхангай аймагт сайн дурын ажилчидтайгаа хамт 1000 модыг тарьж ургах ургалтын системээр хангаж ажилласан.

### Хайртай бүхэндээ хамгаалах бүс



Бичил глобус санхүүгийн нэгдлээс "Хайртай бүхэндээ хамгаалах бүс" аян зарлаж жолооч нартаа зам тээврийн хөдөлгөөнд оролцохдоо бүсээ зүүж, гэр бүлээ хамгаалаарай гэсэн сануулгатай дугаарын тэмдэглэгээг 3,000 ширхэг хэвлэн хотоос гарч буй жолооч нартаа үнэ төлбөргүй тараасан.

### Монголын Залуучуудын Холбоо



2017 онд Монголын Залуучуудын Холбооны дэргэдэх Бичил Глобус санхүүгийн байгууллагын салбар зөвлөлийг байгуулсан.



2024 - 03 - 25

АНХНЫ УҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН АМЖИЛТ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Үнэт цаасны танилцуулга

2024.03.20  
БИРЖИЙН  
ҮҮРГЭВ  
№ 01

АЛТАН ОД ШАГНАЛ



2021 онд Банк бус санхүүгийн салбарын "Шилдгийн шилдэг" Банк бус санхүүгийн байгууллагаар шалгарав.

АЛТАН ОД ШАГНАЛ



2022 онд Банк бус санхүүгийн салбарын "Шилдгийн шилдэг" Банк бус санхүүгийн байгууллагаар шалгарав.

GRAND 2018 ШАГНАЛ



2018 онд Монголын маркетинг менежментийн холбооны Банк, санхүүгийн салбарын шилдэг байгууллага шагнал "Grand гранпри" хүртэв.

НАЙДВАРТАЙ ТАТВАР ТӨЛӨГЧ



2016 онд татвар төлөлтөөрөө дүүрэгтээ тэргүүлж "Найдвартай татвар төлөгч байгууллага"-аар шалгарсан.

ЖУУХ БИЧИГ



2015 онд Хариуцлагатай нийгмийн даатгал төлөгч байгууллагаар шалгаран Нийслэлийн нийгмийн даатгалын газрын "Жуух бичиг"-ээр шагнагдav.

ТАЛАРХАЛЫН БИЧИГ



2013 онд Монгол Улсын Татварын ерөнхий газар-аас Монгол Улсын татвар, хууль тогтоомжийг шударгаар сахиж, улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсанг үнэлэн Талархалын бичгээр шагнав.



2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга

2.5. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН  
САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭОХН  
2024 сар 03 дар  
БҮРТГЭВ  
№ 01

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 7. Санхүү байдлын тайлан, (мянган төгрөг)

Нийт хөрөнгө	2020A	2021A	2022A	2023*
Мөнгөн хөрөнгө	1,522,608	2,386,894	5,542,376	5,314,445
Нийт зээл	24,036,597	42,645,565	64,369,867	81,590,331
Зээлийн эрсдэлийн сан	(798,691)	(369,147)	(350,373)	(722,457)
Факторингийн тооцооны авлага, цэвэр	2,273,101	980,630	225,370	19,242
Эргэлтийн бусад хөрөнгө	843,327	977,935	1,407,174	1,749,348
<b>Эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	<b>27,876,942</b>	<b>46,621,877</b>	<b>71,194,414</b>	<b>87,950,908</b>
Эд хогшил	121,579	144,925	242,585	261,160
Хуримтлагдсан элэгдэл	(65,856)	(86,702)	(112,723)	(128,773)
Тээврийн хэрэгсэл, компьютер ба техник хэрэгсэл	328,263	400,718	710,602	924,976
Хуримтлагдсан элэгдэл	(112,349)	(163,455)	(240,024)	(351,753)
Дуусаагүй барилга	-	-	-	2,415,367
<b>Эргэлтийн бус нийт хөрөнгийн дүн</b>	<b>271,637</b>	<b>295,486</b>	<b>600,440</b>	<b>3,120,977</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>28,148,579</b>	<b>46,917,363</b>	<b>71,794,854</b>	<b>91,071,885</b>

Өр төлбөр ба эздин өмч	2020A	2021A	2022A	2023*
Богино хугацаат зээл	-	10,889,367	14,737,502	8,715,811
Өрийн бичгээрх өглөг	1,567,000	7,343,000	7,782,000	9,341,000
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	1,832,082	9,436,100	13,500,405	24,876,203
Факторингийн үйлчилгээний өглөг	1,606,653	-	-	-
Бусад өр төлбөр	4,743,100	1,435,571	7,526,298	6,718,409
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>9,748,835</b>	<b>29,104,038</b>	<b>43,546,205</b>	<b>49,651,423</b>
Урт хугацаат зээл	5,731,000	-	5,041,000	8,290,000
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>5,731,000</b>	<b>-</b>	<b>5,041,000</b>	<b>8,290,000</b>
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>15,479,835</b>	<b>29,104,038</b>	<b>48,587,205</b>	<b>57,941,423</b>
Энгийн хувьцаа	5,000,000	5,000,000	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	7,668,744	12,813,325	18,207,649	28,130,462
Тайлант үеийн ашиг	3,445,657	5,144,581	5,394,324	9,922,813
Өмнөх үеийн ашиг (алдагдал)	4,223,087	7,668,744	12,813,325	18,207,649
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>12,668,744</b>	<b>17,813,325</b>	<b>23,207,649</b>	<b>33,130,462</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>28,148,579</b>	<b>46,917,363</b>	<b>71,794,854</b>	<b>91,071,885</b>

Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан

2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт хөрөнгө 91.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оноос 26.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт хөрөнгийн сүүлийн 4 жилийн дундаж өсөлт (CAGR) 47.9 хувьд хүрсэн. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нийт хөрөнгө 2023 онд ийнхүү хурдтай өсөхөд урт хугацаат зээл, өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр өмнөх онтой харьцулахад 16.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.




2024-03-25

EYPTGB-02

График 18. Нийт хөрөнгө (эрбум төгрөг) ба хөрөнгийн өсөлт (хувиар)


## Үнэт цаасны танилцуулж

ОН сар өдөр  
2024.03.20  
БҮРГЭВ  
№ 31




Нийт хөрөнгийн бүтцийг задалбал 2023 оны эцэст 88.7 хувь буюу 80.8 тэрбум төгрөгийг зээлийн эрсдэлийн санг хасаж тооцсон цэвэр зээлийн үлдэгдэл эзэлж байна. Бэлэн мөнгө болон банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн дүн нийт хөрөнгөд 5.8% буюу 5.3 тэрбум төгрөгийг бүрдүүлж байна.

График 19. Нийт хөрөнгийн бүтэц, актив талаас (тэрбум төгрөг)



Нийт хөрөнгийн бүтцийг 2023 оны байдлаар эх үүсвэр талаас авч үзвэл 63.6 хувь буюу 57.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг урт ба богино хугацаат зээл, өрийн хэрэгсэл, итгэлцлийн үйлчилгээ, бусад өр төлбөр бүрдүүлж байна. Харин нийт хөрөнгийн 36.4 хувь буюу 33.1 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

График 20. Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас (тэрбум төгрөг)





Үнэт цаасны танилцуулж

2021 оноос эх үүсвэрийн бүтцээ төрөлжүүлэн, 2023 оны эцсийн байдаар итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр 42.9 хувь, богино хугацаат зээл 15.0 хувь, ерийн бичгээр татсан санхүүжилт 16.1 хувийг тус тус эзэлж байна.

График 21. Эх төлбөрийн бүтэц, (тэрбум төгрөг)



Зээлийн багцын чанарын хувьд 2023 оны эцэст хэвийн зээлийн багц 96.9 хувь, хугацаа хэтэрсэн зээл 1.5 хувь, чанаргүй зээлийн дүн 1.6 хувь тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн дүн 1.2 тэрбум төгрөг байгаа бол зээлийн эрсдэлээ удирдах зорилгоор 722.4 сая төгрөгийн эрсдэлийн нөөц сан байгуулжээ.

Бичил глобус финанс ББСБ-ын чанаргүй зээлийн түвшин 1.6 хувь байгаа нь банк бус санхүүгийн салбарын 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх чанаргүй зээлийн 7.5 хувьтай харьцуулахад 4.8 дахин бага үзүүлэлт болж байна.

График 22. Зээлийн багцын чанар, (хувиар)



Ийнхүү анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн багцын чанар маш сайн байгаа нь тус компанийн 2008 оноос хойш тасралтгүй, тогтвортойгоор үйл ажиллагаагаа эрхэлж, харилцагчдын түүхэн мэдээллийн бааз суурь, итгэлцэл, салбарын туршлагыг хуримтлуулж чадсантай холбоотой юм.

Мөн Бичил глобус финанс ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны нэг онцлог нь барьцаатай зээл олгодог бөгөөд нийт зээлийн багцын 86.0 хувь нь автомашин барьцаалсан зээл бөгөөд үлдсэн 14.0 хувь нь үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулсан зээл байна. Эдгээр зээлийн сарын жигнэсэн дундаж хүү нь 3.2 хувь байна.




2024 - 03 - 25

БҮРТГЭВ-02

Хүснэгт 8. Нийт зээлийн бүтэц, бүтээгдэхүүний төрлөөр

Үнэт цаасны танилцуулга



Харьцаа үзүүлэлтүүд	Зээлийн тоо	Нийт зээл, мян.төгрөг	Үүнээс:		
			Хэвийн	Анхаарал хандуулах	Чанаргүй
Иргэн	6,092	81,152,929	78,615,034	1,262,143	1,275,752
Автомашин худалдан авахад зориулсан зээл	5,489	70,111,057	68,091,403	953,795	1,065,859
Үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулсан зээл	603	11,041,872	10,523,631	308,347	209,893
<b>Хуулийн этгээд</b>	<b>6</b>	<b>437,402</b>	<b>437,402</b>	-	-
Автомашины зээл	3	69,382	69,382	-	-
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	3	368,020	368,020	-	-
<b>Нийт</b>	<b>6,098</b>	<b>81,590,331</b>	<b>79,052,436</b>	<b>1,262,143</b>	<b>1,275,752</b>

Иргэдэд олгосон зээлийн багцын дүн нь 81.1 тэрбум төгрөг бөгөөд нэг автомашины зээлд олгосон зээлийн дундаж үлдэгдэл дүн 12.7 сая төгрөг байгаа бөгөөд үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулсан зээлийн дундаж үлдэгдэл 18.3 сая төгрөг байна. Ийнхүү нэгж зээлийн хэмжээг харьцангуй бага түвшинд хадгалсан нь зээлийн багцын эрсдэлээ тархаан байршуулсан эерэг үзүүлэлт болж байна.

Хүснэгт 9. Орлого, үр дүнгийн тайлан, (мянган төгрөг)

Орлого, үр дүнгийн тайлан	2020A	2021A	2022A	2023*
<b>Хүүгийн орлого</b>	8,783,344	10,238,660	20,598,828	26,176,150
Зээлийн хүүгийн орлого	7,901,043	9,708,232	20,402,597	26,137,899
Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	882,301	530,428	196,231	38,251
<b>Хүүгийн зардал</b>	(2,729,947)	(2,285,635)	(6,406,105)	(8,610,299)
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	(2,271,001)	(1,923,164)	(5,226,297)	(7,247,797)
Өрийн бичгийн хүүгийн зардал	(458,946)	(362,471)	(1,179,808)	(1,362,501)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>6,053,397</b>	<b>7,953,025</b>	<b>14,192,723</b>	<b>17,565,851</b>
<b>Хүүгийн бус орлого</b>	76,982	101,362	516,428	1,876,628
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	2,296	775	-	-
Санхүүгийн үйлчилгээний орлого (шимтгэл, хураамж, бусад)	74,686	100,587	516,428	1,876,628
<b>Хүүгийн бус зардал</b>	<b>(1,653,155)</b>	<b>(2,787,053)</b>	<b>(8,726,212)</b>	<b>(6,946,868)</b>
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	(20,967)	(781)	(238,460)	-
Боловсон хүчний зэрдал	(1,073,022)	(1,861,909)	(3,458,694)	(3,622,432)
Бусад үйл ажиллагааны зардал	(559,166)	(924,363)	(5,029,058)	(3,324,436)
<b>Цэвэр хүүгийн бус орлого (зардал)</b>	<b>(1,576,173)</b>	<b>(2,685,691)</b>	<b>(8,209,784)</b>	<b>(5,070,240)</b>
Болзошгүй эрсдэлийн сангаас өмнөх үйл ажиллагааны ашиг	4,477,224	5,267,334	5,982,939	12,495,611
Болзошгүй эрсдэлийн сан	(609,848)	453,758	29,700	(465,222)
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>3,867,376</b>	<b>5,721,092</b>	<b>6,012,639</b>	<b>12,030,389</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,989	36	5,656	
Үндсэн бус үйл ажиллагааны зэрдал	(36,970)	(4,438)	(13,558)	(23,954)
<b>Ердийн үйл ажиллагааны ашиг</b>	<b>3,832,395</b>	<b>5,716,690</b>	<b>6,004,737</b>	<b>12,006,435</b>
Татвар	(386,738)	(572,109)	(610,413)	(2,083,621)
<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>3,445,657</b>	<b>5,144,581</b>	<b>5,394,324</b>	<b>9,922,813</b>


Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан





2023 оны эцсийн нийт цэвэр орлогын хэмжээ 19.4 тэрбум төгрөгт хүрсэн ба 2022 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 32.1 хувиар өссөн байна. Цэвэр ашгийн хэмжээ 2022 онд 5.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4.8 хувиар өссөн бол 2023 онд 9.9 тэрбум төгрөгт хүрчээ. Сүүлийн дөрвөн жилд цэвэр ашгийн дүн жилд дунджаар (CAGR) 42.2 хувиар өсөөд байна.

График 23. Нийт цэвэр орлого ба цэвэр ашиг, (тэрбум төгрөг)




Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан

Бичил глобус финанс ББСБ-ын цэвэр ашгийн маржин 2023 онд 35.4 хувь байгаа бол өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт 30.0 хувь буюу өнгөрсөн оноос 6.8 пунктээр өссөн. Ийнхүү өөрийн хөрөнгийн өгөөж өссөн нь ашигт ажиллагаа сайжирч, эх үүсвэрийн бүтцэд өөрийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ 32.3 хувиас 36.3 хувь болж 9.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.


Бичил глобус финанс ББСБ 2023 оны эцсийн байдлаар 9.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахад хүүгийн бус зардал өнгөрсөн онтой харьцуулахад 1.7 тэрбум төгрөгөөр буюу 20.4 хувиар буурсан, үүнд бусад үйл ажиллагааны зардал 1.7 тэрбум төгрөгөөр буурсан нь цэвэр ашгийн дүн өсөхөд нөлөөлжээ.

График 24. Ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөжийн харьцаа үзүүлэлтүүд



Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан





Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 2023 оны эцэст 434.6 тэрбум төгрөгт хүрсэн ба өнгөрсөн оноос 357.5 тэрбум төгрөгөөр буюу 5.6 дахин өссөн. Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 11.0 сая төгрөгийн алдагдалтай буюу зээл олголт, эх үүсвэрийн ашиглалтын эргэц маш хурдан байгааг илэрхийлж байна.

## Хүснэгт 10. Мөнгөн гүйлгээний тайлан, (мянган төгрөг)

Мөнгөн гүйлгээ	2020A	2021A	2022A	2023*
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>35,297,295</b>	<b>53,186,009</b>	<b>77,145,593</b>	<b>434,653,594</b>
Зээлийн хүүгийн орлого	7,598,131	9,546,224	20,473,443	25,759,758
Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	902,591	592,481	196,365	41,601
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	76,981	76,089	472,056	868,421
Бусад орлого	26,719,592	42,971,215	56,003,729	407,983,814
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>(33,670,959)</b>	<b>(67,496,944)</b>	<b>(65,681,920)</b>	<b>(434,870,454)</b>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн төлбөрт төлсөн	(128,555)	(5,893,358)	(3,818,097)	(6,474,553)
Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал	(5,839)	-	-	-
Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	(443,340)	(242,525)	(583,540)	(1,345,156)
Боловсон хүчиний зардал	(1,025,856)	(1,812,983)	(2,485,265)	(4,208,462)
Бусад мөнгөн зарлага	(32,067,369)	(59,548,078)	(58,795,018)	(422,842,283)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,626,336</b>	<b>(14,310,935)</b>	<b>11,463,673</b>	<b>(216,860)</b>
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	19,905,304	64,141,538	98,097,392	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	(21,370,475)	(48,966,317)	(106,405,583)	(11,071)
<b>Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,465,171)</b>	<b>15,175,221</b>	<b>(8,308,191)</b>	<b>(11,071)</b>
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	161,165	864,286	3,155,482	(227,931)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,361,443	1,522,608	2,386,894	5,542,376
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,522,608	2,386,894	5,542,376	5,314,445

Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан

2023 оны эцэст Бичил глобус финанс ББСБ-ын эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.3 тэрбум төгрөг байна. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл жилд дунджаар 51.6 хувиар нэмэгдэж байгаа нь тус компанийн богино хугацаанд түргэн хөрвөх чадварыг нэмэгдүүлж байна.

## Хүснэгт 11. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	2020A	2021A	2022A	2023*
Эргэлтийн харьцаа (current ratio)	2.9	1.6	1.6	1.8
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа (quick ratio)	2.8	1.6	1.6	1.7
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн харьцаа (cash ratio)	0.16	0.08	0.13	0.11
Өр зээл ба бэлэн мөнгөний харьцаа (Total loan to total deposit ratio)	7.1	11.6	7.4	9.6

Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан





Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийн харьцаа 2023 оны эцэст 11.0 хувь орчимд хадгалагдаж байна. Эргэлтийн харьцаа буюу богино хугацаат хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах чадвар 1.8 буюу маш сайн байна. Эргэлтийн хөрөнгөд нийт зээлийн багц харьяалагдаж байгаа учраас эргэлтийн хөрөнгийн дүн богино хугацаат өр төлбөрөөс давсан үзүүлэлттэй байна.

График 25. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг)



Тайлбар: А-Аудитлагдсан санхүүгийн тайлан, \*-Урьдчилсан санхүүгийн тайлан

#### Хүснэгт 12. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Зохистой үзүүлэлт	Шалгуур	Тайлангаар	Шалгуур хангасан эсэх
<b>Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт</b>			
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	36.5%	Тийм
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	36.5%	Тийм
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	36.4%	Тийм
<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа</b>			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	10.7%	Тийм
<b>Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт</b>			
Хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, - дутуу)	730,189.3	730,189.3	Тийм
Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	0.6%	Тийм
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-аас хэтрэхгүй	0.0%	Тийм
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	25%-аас хэтрэхгүй	1.0%	Тийм





2024 -03- 25

ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЭЗМШИГЧ, ТУЗ,  
ГҮЙЦТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГОХ НЭГ  
ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛГАН  
ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН  
БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

10%-аас хэтрэхгүй

0.2%

Үнэт цаасны танилцуулга



Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн  
зохистой харьцаа

50%-аас  
хэтрэхгүй

0.0%

Тийм

Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн  
зохистой харьцаа

20%-аас  
хэтрэхгүй

0.0%

Тийм

Монголын хөрөнгийн биржийн "I", "II"  
ангиллын нэг компанийн гаргасан  
хувьцаанаас худалдаж авах зохистой  
харьцаа

20%-аас  
хэтрэхгүй

0.0%

Тийм

Компанийн өрийн бичиг өөрийн  
хөрөнгийн зохистой харьцаа

20%-аас  
хэтрэхгүй

0.0%

Тийм

Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн  
зохистой харьцаа

10%-аас хэтрэхгүй

-

Тийм

#### Гадаад валютын ханшийн эрсдэл

Гадаад актив, пассивын зөрүү өөрийн  
хөрөнгийн зохистой харьцаа

±40% хооронд

0.0%

Тийм

#### Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд

Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн  
хөрөнгийн зохистой харьцаа

80%-аас  
хэтрэхгүй

75.1%

Тийм

Өрийн бичгийн зохистой харьцаа

50%-аас  
хэтрэхгүй

28.2%

Тийм

#### Үндсэн хөрөнгийн үзүүлэлт

Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа

15%-аас хэтрэхгүй

3.4%

Тийм

#### Өгөөж

Хөрөнгө (актив)-ийн өгөөж

12.2%

Өөрийн хөрөнгийн өгөөж

35.2%

Эх сурвалж: Бичил глобус финанс ББСБ-ЫН СЗХ-НД ТАЙЛАГНАСАН  
2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Банк бус, санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг  
Бичил глобус финанс ББСБ нь 2023 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар бүрэн  
хангаж ажиллаж байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайн,  
төлбөр түргэн гүйцэтгэх чадвар шалгуурыг хангасан байгаа бол актив хөрөнгийн  
төвлөрлийн үзүүлэлт болох нэг этгээд эсвэл хамааралтай талуудад олгох зээлийн  
шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажиллаж байна.

Мөн өөрийн хөрөнгийн 80.0 хүртэлх хувийн үнийн дүнтэй тэнцэх итгэлцлийн  
үйлчилгээний эх үүсвэр болон өөрийн хөрөнгийн 50.0 хувь хүртэлх дунгээр өрийн  
хэрэгсэл татах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байна.  
Мөн банк бус, санхүүгийн байгууллагын үндсэн хөрөнгийн зохистой харьцаа нь 15  
хувиас хэтрэхгүй байх шалгуурыг хангаж байна.





Үнэт цаасны танилцуулга



## 26. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, түүнийг хэрхэн удирдах талаар дараах эрсдэлийн удирдлагын арга хэмжээг авч ажилладаг.

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

#### Макро эдийн засгийн эрсдэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтмол хянан, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдал, эрсдэл даах чадварыг үнэлж, зээлийн багцын төвлөрлөөс сэргийлэх зорилгоор СЗХ-ноос тогтоосон зохистой харьцааны шалгуурыг хангах, мөн холбогдох журмуудыг мөрдлөг болгох зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг.

#### Хууль эрх зүйн орчин, зохицуулалтын эрсдэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үйл ажиллагаанд дааж мөрдөх шаардлагатай холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөрдөх замаар эрх зүйн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### Зээлийн эрсдэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн үйл ажиллагаанд нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг үнэлж, учирч болох эрсдэлийн түвшинг тооцон, зээлийн үнэ цэнийн бууралт, чанарын удирдлагын арга аргачлалыг сайжруулан, эрсдэлтэй зээлд баримтлах зарчим, арга ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн гаргасан зээлийн хувьд тогтмол хяналт тавин үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан ажилладаг.

#### Хүүгийн эрсдэл

Зээлийн хүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор зах зээлийн хүүгийн нөхцөл байдлын шинжилгээ болон бусад зохистой харьцаа, хязгаар үзүүлэлтийг харгалzan зээлийн хүүг эх үүсвэрийн өртөгтэй уялдуулан тогтоодог.


#### Үйл ажиллагааны эрсдэл

Дотоод үйл ажиллагаа, хяналтын систем, хүний хүчин зүйл болон технологийн доголдлоос бий болж болзошгүй аливаа эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажилладаг.


#### Төлбөрийн болон хөрвөх чадварын эрсдэл

СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажилладаг бөгөөд санхүүгийн мөнгөн урсгалаа тогтмол төлөвлөж, гүйцэтгэлд хяналт тавих болон дотоодын санхүүгийн байгууллагад зээлийн эрх нээлгэх замаар хөрөнгөт чадварын эрсдэлээс сэргийлэн ажилладаг. Мөн эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийн оновчтой төлөвлөлт хийх замаар төлбөрийн чадварын КО КАПИТАЛТЫК ХАК 45 6183855 9021031195 СТС2420





Үнэт цаасны танилцуулга



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

**БҮРТГЭВ-02**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь эрсдэлийн засаглалын бүтцийн дагуу эрсдэлийн удирдлагын "Гурван давхар хамгаалалтын шугам"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг.

Схем 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрсдэлийн удирдлагын бүтэц



## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ДОТООД ЖУРМУУДЫН ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 23/01a/01 тоот тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын шинэ кодексыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах холбогдох журмуудыг баталжээ. Үүнд:

- **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам** Энэхүү журмаар ТУЗ-ийн бүрэн эрх, түүний бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, сонгох, хугацаанаас өмнө чөлөөлөх журам, дарга, гишүүд, нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага, ТУЗ-ийн хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах, үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зэрэг харилцааг зохицуулж байна.
- **Дотоод хяналт, аудитын үйл ажиллагааны журам** Тус журамд компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын зохистой тогтолцоог бүрдүүлэх нь гүйцэтгэх захирлын үүрэг байх тухай зааж өгсөн бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлангийн талаар, хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах, комплайнсийн талаар, дотоод аудиторын эрх, үүрэг, аудиторын хараат бус байдал, дотоод аудитын үйл ажиллагааг удирдах ТУЗ-ийн бүрэн эрх, дотоод аудитын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэл зэрэг дотоод журмын заалтуудыг тусгажээ.
- **Эрсдэлийн удирдлагын бодлого, журам** Энэхүү журмын зорилго нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, баримтлах зарчим, эрсдэлийн ангиллыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шатыг тогтоох,





Үнэт цаасны танилцуулга



эрсдэлийн удирдлагын тогтолцоог бурдуулэх, эрсдэлийг удирдахтай холбогдон ажилтан, албан тушаалтан бүрийн эрх, үүргийг тодорхойлох, хянахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах юм.

- Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгох журам** Хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт өгөх, аудитын байгууллагын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллагааг энэхүү журмаар зохицуулж байна.
- Залгамж халааны бодлого** Тус журмаар ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын багийн гишүүдийн залгамж халааг бэлдэх үйл ажиллагааг зохицуулахад оршино. ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын залгамж халаа гэдэг нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх дээд удирдлагын орон тоо гарсан тохиолдолд тэдний оронд сонгох хүний нөөцийг ойлгоно.
- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам** Энэхүү журмаар компаниас хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчдад болон нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгсэл (нэвтрүүлэх, нийлүүлэх мэдээллийн хэрэгсэл, давтамж), хариуцах албан тушаалтан зэргийг тогтооно. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь нийтийн хүртээл болгох замаар компанийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, дотоод буюу нийтийн хүртээл болоогүй мэдээллийг шударга бусаар ашиглахаас сэргийлэх нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг байна.
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам** Тус журмаар компанийн хэмжээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулах ба хэлцэл хийх журам, сонирхлын зөрчилтэй этгээдэд тавих шаардлага, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний үр дагавар, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас үүсэх хохирлыг арилгах, хариуцлагын талаар тусгажээ.
- Мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдох сонирхлын зөрчлийг зохицуулах журам** Бичил глобус финанс ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа болох зээлийн болон итгэлцлийн үйл ажиллагаатай холбогдон компани, ажилтнууд болон компани хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн хооронд үүсч болох сонирхлын зөрчлийг бууруулах, үүссэн үед ил тод тайлагнах замаар хөрөнгө оруулагчид, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам** Энэхүү журмын зорилго нь Бичил глобус финанс ББСБ-ын хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, тэд нарт мэдээлэл хүргэх чиглэл, зарчмыг тогтооход оршино.
- Шүгэл үлээх үйл ажиллагааг зохицуулах журам** Тус журмаар компанийн хэмжээнд шүгэл үлээх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилготой. Мөн энэ журамд шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээх ажиллагааг хэрэгжүүлэх, шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ, хариуцлага зэрэг зохицуулалтыг тусгасан байна.
- Ёс зүйн дүрэм** Энэхүү журмаар Бичил глобус финанс ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд болон бүх ажилтнуудын баримтлах ёс зүйн зарчим, дүрмийг тогтоож өгсөн байна. Мөн ажилтан үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ баримтлах зарчим, хариуцлагыг Ёс зүйн дүрэмдээ оруулсан байна.



700-00-25  
БҮРЛГЭЗ-02

0%  
100% 98.780%  
100% 100% 100%

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



## ГУРАВ. Үнэт цаас гаргагчийн тухай

# БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ



2024-03-25

### 3.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс Лоялти ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгын хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Үүсгэн байгуулагчийн дурмийн холбогдох заалтыг үндэслэн Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 23/01a/17 тоот шийдвэрээр үүсгэн байгуулагдсан.

Үнэт цаас гаргагч нь 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 779 дугаар тогтоолоор олгогдсон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд Тусгай зориулалтын компани буюу Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК болж компанийн үйл ажиллагааны чиглэл болон компанийн нэршлээ өөрчилсөн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй байна.

Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

Байгууллагын нэр	Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК
Хувьцаа эзэмшигч	Бичил глобус финанс ББСБ ХХК
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
Үүсгэн байгуулагдсан огноо	2023.09.25
Улсын бүртгэлийн дугаар	9011856540
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо	2023.09.29
Регистрийн дугаар	8419868
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж, 101 барилга, 705 тоот
Утас	+976 9911-9632
Үнэт цаас гаргагчийн захиргааны үйлчилгээ үзүүлэгчийн цахим шуудан, цахим хаяг	<a href="mailto:info@bichilglobus.mn">info@bichilglobus.mn</a> , <a href="http://www.bichilglobus.mn">www.bichilglobus.mn</a>
Шуудангийн хаяг	-
Биржид бүртгэлтэй эсэх	Үгүй

Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл

Зарласан буюу гаргасан хувьцааны тоо	1,000.0 (нэг мянга) ширхэг
Хувьцааны төрөл	Энгийн хувьцаа
Нэрлэсэн үнэ	1,000.0 (нэг мянга) төгрөг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000.0 (нэг сая) төгрөг
Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр	"Бичил глобус финанс ББСБ" ХХК
Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд, эзлэх хувь	100.0 (нэг зуун) хувь буюу 1,000.0 (нэг мянга) ширхэг энгийн хувьцаа



Үнэт цаасны танилцуулга

2024-09-20 өдөр

ҮТРГГЭВ  
№ 015183855 49  
0021031195 CTC2420

СЭХ  
02-01-23

БҮРГЭЭС 00

Үнэт цаасны танилцуулга  
СЭХ  
02-01-23  
БҮРГЭВ  
01-01-23

### 3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах СЭХ-ны тусгай зөвшөөрөлтэй тусгай зориулалтын компани тул бүтэц, зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эрх, үүрэг нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЭХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам" болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулагдан үйл ажиллагаагаа явуулна.

#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ (ХЭХ)

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байх ба компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлэхээр заажээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх хэмжээг Компанийн тухай хуулиар зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

Схем 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлууд

СЭХ-ны зөвшөөрлийг үндэслэн Үнэт цаас гаргагчийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу Үнэт цаас гаргагчийн дүрмийн шинэчилсэн дүрмийг батлах ба энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Дүрэмд нэмэлт өөрчлөлтийг хөрөнгө оруулагчдад ажлын З хоногийн дотор мэдэгдэх;

Үнэт цаас гаргагчийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

Үнэт цаас гаргагчийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох;

Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

Хууль тогтоомжид заасан бусад асуудал;

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЭХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам болон Компанийн дүрэмд зааснаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тухай хууль тогтоомжид заасан бусад хязгаарлалтын хүрээнд эрхээ хэрэгжүүлнэ. Үүнд:





- ТЗК-ийн хувьцаа эзэмшигчид нь СЗХ-ноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй;
- Үнэт цаас гаргагчийн эсрэг өөрийн шаардлага, эсвэл түүний өмнө Үнэт цаас гаргагчийн аливаа хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотойгоор аливаа хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Үнэт цаас гаргагчид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгөх эрхгүй;
- Хууль болон Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 8.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн татан буулгахаар хүсэлт гаргах эрхгүй байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)

Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 4.3 дахь хэсэгт Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ хэрэгжүүлэхээр тусгасан. Иймд Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Компанийн тухай хууль болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан үүргийг хэрэгжүүлнэ.

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
- Компанийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
- Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх;
- Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих;
- Компанийн дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах;
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах;
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах;
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх;
- ТЗК-ийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;
- ТЗК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгон гаргасан үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;





- ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;
- Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;
- Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Хороо болон Биржээс баталсан журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

Санхүүгийн зохицуулах хорооны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасны дагуу ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн ТЗК татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь энэхүү үнэт цаасны танилцуулгын үнэн зөвийг бүрэн хариуцна.

Үнэт цаас гаргагчийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/27а/03 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилсон бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 23/27а/04 дугаар тогтоолоор ТУЗ-ийн даргаар Н.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Д.Энхчимэг нарыг сонгосон байна.

Компанийн тухай хуулийн дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилсон бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан хэрэгжүүлж байгаа болно. Иймд ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТЗК-ийн ажилтан гэж үзэхгүй ба ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5-д заасан шаардлагыг хангасан болно.

Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

 <b>Боловсрол</b> <ul style="list-style-type: none"> <li>• 2011-2012, Газарчин их сургууль, Бизнесийн удирдлагын магистр;</li> <li>• 2001-2005, ШУТИС, Математик загварчлал, Бакалавр;</li> <li>• 1991-2001, Увс аймаг, 1-р сургууль, Бүрэн дунд.</li> </ul> <b>Ажлын туршлага</b> <ul style="list-style-type: none"> <li>• 2019-Одоо, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Салбарын удирдлагын мэргэжилтэн, Зээлийн газрын захирал;</li> <li>• 2017-2019, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Салбарын захирал;</li> <li>• 2015-2017, “Бичил глобус финанс ББСБ” ХХК, Зээлийн менежер;</li> <li>• 2014-2015, “Аварга Соёо” ХХК, Оффис менежер;</li> </ul>	      
--	--------------------------




 <p><b>M.Oyuuntuya</b> ТУЗ-ийн Хараат бус гишүүн</p>	<p><b>Боловсрол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2015-2016, СЭЗИС, Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнесийн удирдлагын магистр;</li> <li>• 2004-2008, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Банкны эдийн засгийн бакалавр;</li> <li>• 1994-2004, Сэлэнгэ аймаг, Түшиг сум, Бүрэн дунд.</li> </ul> <p><b>Ажлын туршлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2018-Одоо, "Лингорс" ХХК, Гүйцэтгэх захирал;</li> <li>• 2017-2018, "Компанийн засаглалын хөгжлийн төв", Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны менежер;</li> <li>• 2008-2017, "Капитал банк", Эрсдэлийн удирдлагын газрын захирал, Хөрөнгө оруулалтын удирдлагын газрын захирал.</li> </ul>
 <p><b>D.Baatarjav</b> ТУЗ-ийн Хараат бус гишүүн</p>	<p><b>Боловсрол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2017-2019, АНУ, Бриджпортын сургууль, Санхүүгийн шинжлэх ухааны магистр;</li> <li>• 2009-2013, СЭЗИС, Санхүү менежмент, Бакалавр;</li> <li>• 2007-2009, Байгаль-Эх лицей, Бүрэн дунд.</li> </ul> <p><b>Ажлын туршлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2023-Одоо, "Мазаалай капитал партнерс ҮЦК" ХХК, Гүйцэтгэх захирал;</li> <li>• 2021-2023, "Мандал Ассет Менежмент ҮЦК" ХХК, Дэд захирал;</li> <li>• 2020-2021, "Мандал даатгал" ХК, Хөрөнгө оруулалтын менежер;</li> <li>• 2013-2016, "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК, Хөрөнгө оруулалтын ахлах шинжээч.</li> </ul>
 <p><b>D.Eenkhchim</b> ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</p>	<p><b>Боловсрол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2007-2011, Мандах бүртгэл дээд сургууль, Банкны эдийн засаг-Нягтлан бодох бүртгэл, Бакалавр;</li> <li>• 1998-2007, Улаанбаатар хот, 2-р сургууль, Бүрэн дунд.</li> </ul> <p><b>Ажлын туршлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 2021-Одоо, "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Санхүүгийн шинжээч;</li> <li>• 2011-2021, "Голомт банк", Харилцагчийн үйлчилгээний ажилтан, Харилцагчийн үйлчилгээний менежер, Нягтлан бодогч, Даатгал хариуцсан менежер, Дата аналист.</li> </ul>

**ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ**

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 24/790 дугаартай "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-г нэг талаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК, нөгөө талаас Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс Лоялти ТЗК ХХК нар байгуулсан. Тус гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү гэрээнд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан зээлийн авлагын эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулах зорилготой.

Үнэт цаас гаргагч нь хэлцэл биелэх өдөр зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг багц болгон худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг энэхүү гэрээнд заасны дагуу солих, хөрөнгийг багцыг гэрээнд заасан үндэслэлээр нэмэх нөхцөлтэйгээр худалдахаар тохиролцсон байна. Талууд гэрээгээр хүлээсэн үргээ үнэнч шударгаар биелүүлж, харилцан бие биеийн ашиг сонирхлыг хүндэтгэх, гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог тууштай хадгалах бөгөөд Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үргэлжлэх хугацаанд талууд Хөрөнгө оруулаг





МЭДЭЭЛЭЛ

БҮРГЕССЭР

буюу үнэт цаас эзэмшигчийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж идэвхтэй, шуурхай эв бүтээлчээр хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Үнэт цаасны танилцуулга



### Хөрөнгө худалдах үндсэн нөхцөл

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2-т зааснаар ТЗК нь Хөрөнгийг шилжүүлэн авснаар тухайн Хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, фидуци, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хөрөнгөтэй хамт шилжүүлэн авсанд тооцно.
- Худалдах хөрөнгийн хэмжээг Бичил З ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дуусах өдрийн байдлаар хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох бөгөөд уг дүн нь тус гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан Хэлцэл биелэх үнэ (20,000,000,000.0)-тэй тэнцүү байна.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийг худалдан шилжүүлэх жагсаалт үйлдэн шилжүүлэх бөгөөд хөрөнгийг солих болон нэмж худалдаж болох нөхцөлтэйгөөр худалдаж байгаа болно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11, 14.3-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо Хөрөнгийн багцыг бүртгэсэн өдөр уг багцад орсон хөрөнгийг ТЗК-ийн өмчлөлд шилжсэнд тооцно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээлдэгчийн зээлтэй холбоотой зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг үнэт цаас гаргагчид хүргүүлэх, хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг хариуцан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж, уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэг хүлээнэ.


### Зээлийн данс бүртгэл хөтлөх, баримт бичгийг хадгалах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлээс тусад нь данс бүртгэл үүсгэн хадгалах бөгөөд санхүүгийн тайлан тэнслийг тусад нь хөтөлж холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална.
- Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч, мөн бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй.
- Үнэт цаас гаргагч нь дээрх шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт УЛААНБААТАР ХОТ ӨЗИЙ ЭНД КО АНХНЫ ХҮРЭГ ТОМИЛОГДСОН АЖИЛТНЫГ АЖИЛЛАХ БОЛОМОJOОР ХАНГАХ ҮҮРГИЙГ АНХНЫ ХҮРЭГ томилогдсон ажилтныг ажиллах боломжоор хангах үүргийг АНХНЫ ХҮРЭГ





ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ ХҮЛЭЭНЭ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тайланг хүлээн авч хянан баталгаажуулна.



### Барьцааны зүйл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2 дахь заалтын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээний дагуу худалдах, солих, нэмэх зэргээр ТЗК-д шилжүүлэх Хөрөнгийн багцын авлагын эрхийг баталгаажуулах зорилгоор багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, барьцаа, фидуци, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа бусад арга, санхүүгийн хэрэгсэл зэрэг орно)-ийг ТЗК-д шилжүүлж барьцаалуулна.

### Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээний хэлцэл биелэгдэх өдөр байгуулна.
- Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ББСБ нь хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийг Зээлдэгчдээс цуглуулан үнэт цаас гаргагчид сар тутамд сарын төлбөрийн хуваарыт өдөр шилжүүлэх, ТЗК нь үйлчилгээний төлбөр болон шимтгэл төлөх үүрэг хүлээнэ.

### Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах


- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийг буцаан худалдаж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг хөрөнгийг бусад гуравдагч этгээдэд худалдах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь гуравдагч этгээдэд хөрөнгө худалдсанаас үүссэн хохирлоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд түүнд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй болно.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хөрөнгийг буцаан худалдахдаа Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний тусгай нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан доорх нөхцөл байдал үүссэн тохиолдолд ТЗК-ийн “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-аар тогтоосон зарчмын дагуу буцаан худалдана.

- \* Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- \* Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- \* Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн баталгаа

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргасан болно:

- \* Хөрөнгийн багц дахь хөрөнгө нэг бүр нь Хэлцэл биелэх өдрийн байдлаар хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангасан КО КАПИТАЛ УЦК ХК





2024-05-25

БҮРГИССААР

Үнэт цаасны танилцуулга

2024.05.26

адар

\* Гэрээ болон түүнд хавсаргасан мэдээллүүд нь (гэрээ болон хা঵сралтад заасан хөрөнгө, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой баримт бичиг мэдээлэл) үнэн зөв.

- \* Хөрөнгийг Үнэт цаас гаргагчид бүрэн шилжихэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй.
  - \* Хөрөнгийн багц дахь хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, зээлийн гэрээнд зааснаас бусад нэмэлт үүрэг байхгүй болно.
  - \* Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгч, зээлдэгчийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл, дампуурлын хэрэг зэргийн талаар мэдэгдэл, мэдээлэл аваагүй болно.
  - \* Хөрөнгийн багц дахь зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан Үнэт цаас гаргагчид дараах баталгааг Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээгээр гаргасан болно.
- \* Гэрээ болон ХБҮЦ гаргахтай холбоотой бусад холбогдох гэрээ хэлцэл түүний дотор үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд эдгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр, холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй.
  - \* Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрээ байгуулах, гэрээний дагуу хөрөнгө шилжүүлэх, барьцаалах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдсөн.
  - \* Гэрээгээр худалсан хөрөнгийн эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхэд ямар нэгэн зөрчилгүй бөгөөд тухайн эрх шилжүүлэлтийг бүртгүүлэх, дуусгавар болгоход аливаа хязгаарлалт байхгүй.
  - \* Хөрөнгийн багц дахь зээл бүртэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгч болон бусад этгээдэд төлөх өр төлбөр байхгүй.





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

### 3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь Компанийн дүрэмд зааснаар нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1,000 ширхэг зарласан болон гаргасан энгийн хувьцаа бүхий 1,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулагдсан.

Үнэт цаасны танилцуулга

Онцлог сар № 01  
БҮРТГЭВ  
№ 01

Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн санхүүгийн тайлан, тэнцэл

Nº	Үзүүлэлт	Актив	Пассив
1	Мөнгөн хөрөнгө	1,000,000	-
2	Хувь нийлүүлсэн хөрөнгө	-	1,000,000
	Тэнцэл	1,000,000	1,000,000

### 3.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27а/04 тоот “Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолоор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулах хугацааны буюу 2024-2026 оны санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

#### САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөллийг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлт дээр үндэслэн дараах байдаар төсөөлсөн болно. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үндсэн төлбөрийг ХБҮЦ-ны хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 24 сарын хугацаанд хагас жил тутамд 4 удаа тэнцүү хуваан төлөх бөгөөд тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 24 дахь сар дээр нийт зээлийн үлдэгдэл үнэт цаасны нийт үндсэн төлбөрийн дүнгээр буурах төсөөлөлтэй байна.

Хүснэгт 17. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	О улирал	I улирал	II улирал	III улирал	IV улирал	V улирал	VI улирал	VII улирал	VIII улирал
Бэлэн мөнгө	1	4,381	3,222	7,729	7,634	12,263	10,264	12,681	10,041
Нийт зээл	25,678	22,303	19,437	15,833	11,628	7,544	4,931	2,854	-
Эрсдэлийн сан	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт хөрөнгө	25,679	26,683	22,660	23,562	19,263	19,807	15,195	15,535	10,041
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг	20,000	20,000	15,000	15,000	10,000	10,000	5,000	5,000	-
Бусад өглөг	5,678	5,677	5,677	5,677	5,677	5,677	5,677	5,677	4,950
Өр төлбөрийн дүн	25,678	25,677	20,677	20,677	15,677	15,677	10,677	10,677	4,950
Хувьцаат капитал	1	1	1	1	1	1	1	1	1
Хуримтлагдсан ашиг	-	-	1,005	1,981	2,884	3,585	4,129	4,517	4,857



2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга

Татварын дараах ашиг	СҮРГЭВ-02	1005	976	902	701	545	388	340	233
Нийт өөрийн хөрөнгө		1,006	1,982	2,885	3,586	4,130	4,518	4,858	5,091
Өр төлбөр ба эздин өмч		25,679	26,683	22,660	23,562	19,263	19,807	15,195	15,535
									10,041

Үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9.2 дахь заалтад баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан тохиолдолд татан буугдах тухай заасны дагуу ТЗК нь татан буугдаж, холбогдох хөрөнгийг үүсгэн байгуулагч буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК руу шилжүүлнэ.

## ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг гаргахдаа Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж буй зээлийн багцаас орох мөнгөн урсгал болон үйл ажиллагааны төсөвлөгдсөн зардалд үндэслэж дараах төсөөллийг боловсруулсан.


Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл

Сая төгрөг	I улирал	II улирал	III улирал	IV улирал	V улирал	VI улирал	VII улирал	VIII улирал
Хүүгийн орлого	2,280	2,257	1,943	1,717	1,273	1,035	720	596
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр	(925)	(925)	(694)	(694)	(463)	(463)	(231)	(231)
Цэвэр хүүгийн орлого	1,355	1,332	1,249	1,024	811	573	489	365
Эрсдэлийн сангийн зардал	-	-	-	-	-	-	-	-
Эрсдэлийн сангийн дараах ашиг	1,355	1,332	1,249	1,024	811	573	489	365
Үйл ажиллагааны зардал	(238)	(247)	(246)	(245)	(206)	(142)	(111)	(106)
Татварын өмнөх ашиг	1,117	1,085	1,002	779	605	431	378	259
Татвар	(112)	(108)	(100)	(78)	(61)	(43)	(38)	(26)
Татварын дараах цэвэр ашиг	1,005	976	902	701	545	388	340	233

## ЗАРДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/03 тоот тогтоолын Хавсралт 9-өөр баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүгийн болон үндсэн төлбөрийг үнэт цаас эзэмшигчид олгохоос гадна ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардалд төсвийг зарцуулна.

Үүнд татвар, төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал, тэргэнд өөрөөр заагаагүй бол ХБҮЦ гаргах, хадгалалттай холбоотой зардал, банктай



**2024-03-25**
**Үнэт цаасны танилцуулга**
**2024-03-20**

холбоотой зардал, хөрөнгө итгэмжлэн удирдагч, үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн аудитын болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөр, ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой өрөнхий болон удирдлагын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб хуудастай холбоотой зардал, санхүүгийн программтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал, бичиг хэргийн зардал) багтана.

Хүснэгт 19. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал

№	Зардлын зориулалт	Дүн	Давтамж
1	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр	Удирдаж буй хөрөнгийн 1.00 хувь	Сар бүр
2	Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр	Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь	Сар бүр
3	Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр	Жилд 7.5 сая төгрөг	Жил бүр
4	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	Нийт 24 сая төгрөг	Улирал бүр
5	Зээлийн программ хангамжийн төлбөр	15,840,000 төгрөг	Элсэлтийн хураамж (нэг удаа)
6	Захиргааны зардал	Сард 1.5 сая төгрөг	Сар бүр

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр


Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юу Эй Эф Ассет Менежмент ХХК-ийн хооронд байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-ний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгийг удирдах үүрэгтэй. Иймд тус үйлчилгээний төлбөр болгож удирдаж буй нийт хөрөнгийн 1.00 хувиар тооцож сар бүр Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани болох Юу Эй Эф Ассет Менежмент ХХК-д төлөх юм.

### Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Бичил глобус финанс ББСБ ХХК-ийн хооронд байгуулсан “Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу Үйлчилгээ үзүүлэгч Бичил глобус финанс ББСБ ХХК нь зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж, дараа сарын 25-ны өдөрт багтаан үйлчилгээний хөлсийг хасаж тооцсон дүнгээр Төлбөр цуглуулах данс руу шилжүүлсэн байх үүрэгтэй. Энэхүү үйлчилгээний төлбөр нь цуглуулсан төлбөрийн 2.5 хувьтай тэнцэнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын 2.3.4-т заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг нэгтгэн гаргаж, дараа сарын ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн тайлagnana.

### Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр

Санхүүгийн зохицуулах хорооны “ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 10.1-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх шаардлагатай юм. Иймд Үнэт цаас гаргагч нь Ниймээзийн аудит ХХК-тай Аудитын үйлчилгээ үзүүлэх №24/8419868 дугаартай гэрээг 2023 оны 11 дээрээ





сарын 20-ны өдөр байгуулсан. Тус гэрээнд зааснаар аудитын үйлчилгээний төлбөр жилийн 7.5 (долоо аравны тав) сая төгрөг байх юм.

## Ерөнхий ба удирдлагын зардал

Үнэт цаас гаргагч компанийн ерөнхий ба үйл ажиллагааны зардал нь эхний жилд улиралд дунджаар 244.0 сая төгрөг байхаар төсөвлөсөн байна.


## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл

Сая төгрөг	I улирал	II улирал	III улирал	IV улирал	V улирал	VI улирал	VII улирал	VIII улирал
Хүүгийн орох мөнгөн урсгал	2,210	2,063	1,777	1,399	958	588	346	145
Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал	6,005	6,513	6,783	6,788	5,965	3,789	2,783	2,482
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	-	(5,000)	-	(5,000)	-	(5,000)	-	(5,000)
ХБҮЦ-ны хүүгийн төлбөр	(925)	(925)	(694)	(694)	(463)	(463)	(231)	(231)
Үйл ажиллагааны зардал	(238)	(247)	(246)	(245)	(206)	(142)	(111)	(106)
Татварын зардалд төлсөн төлбөр	(112)	(108)	(100)	(78)	(61)	(43)	(38)	(26)
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	6,941	2,295	7,519	2,172	6,195	(1,271)	2,749	(2,736)
Хадгаламж, Хөрөнгө оруулалтын хүүгийн орлого	70	194	165	318	315	447	374	451
Банкны хадгаламж	70	194	165	318	315	447	374	451
Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт	(2,630)	(3,648)	(3,178)	(2,584)	(1,881)	(1,175)	(706)	(355)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал	(2,560)	(3,454)	(3,013)	(2,266)	(1,566)	(729)	(332)	97
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1	4,381	3,222	7,729	7,634	12,263	10,264	12,681
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,381	3,222	7,729	7,634	12,263	10,264	12,681	10,041
(Харилцах, хадгаламж+Зээл)/ХБҮЦ	138%	160%	168%	211%	215%	330%	335%	-

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хугацаа нь 24 сарын хугацаатай үргэлжилж, үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрөө төлж дуусах тул багцын хөрөнгийн орж ирэх мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны хуваарьт төлбөр төлөлттэй цаг хугацааны хувьд уялдаатай байх ёстой.





Үнэт цаасны танилцуулга

04 сар, 21 өдөр

Зээлийн хөрөнгийн багцад багтаж буй зээлийн гэрээнүүдийн дундаж үргэлжлэх в хугацаа зээлийн үлдэгдлээр жигнэж тооцвол 33.5 сар байгаа нь үнэт цаасны хугацаа болох 24 сараас урт хугацаатай боловч ТЗК-ны мөнгөн урсгалын төсөөллийг харгалzan дараах үндэслэлээр хөрөнгийн багц нь ХБҮЦ-ны үүргийг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- Хөрөнгийн багц дахь зээлүүдийн эргэн төлөлт бүхэлдээ илүү төлөлтгүй, хугацаа хэтэрсэн зээлгүй байх тохиолдолд зээлийн багцын хүүгийн болон үндсэн төлбөрийн эхний 24 сарын нийлбэр дүн нь нийт ХБҮЦ-ны гүйцэтгэх үүргийн 100 хувийг гүйцэтгэхд хүрэлцэнэ;
- Нийт багцын 80 хувь төлөгдсөн тохиолдолд ТЗК-иас хөрөнгийн багцыг буцаан худалдах нөхцөлийн дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид үлдэгдэл багцыг буцаан шилжүүлж ХБҮЦ-ны хэлцэл дуусгавар болох;

### 3.5. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

#### ТӨЛБӨР ЦУГЛУУЛАХ ДАНС

ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын 3.2-т заасан буюу дараах үндэслэлээр Төлбөр цуглуулах данснаас гүйлгээ гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийг ҮЦТХТ-ийн данс руу шилжүүлэх;
- Үнэт цаасны хүүгийн орлогын татвар;
- Хөрөнгийн багцад хөрөнгө нэмж худалдан авах, солих, нэмэгдүүлэх;
- Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах;
- ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал.

#### ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ДАНС

Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн багцын зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу Зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг уг дансанд төвлөрүүлж, дараа сарын 25-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах дансанд шилжүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг сар бүр нэгтгэн гаргаж, дараа сарын ажлын 3 өдөрт багтаан ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид хүргүүлэн, тайлагнана.





20/4-03-25

### 3.6. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСЫГ БУЦААН ХУДАЛДАХ НӨХЦӨЛ

Үнэт цаасны танилцуулга



Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагч нь буцаан худалдан авна. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн (баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд) бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

### 3.7. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл<sup>1</sup> авсан.

"Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК нь ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглувуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

<sup>1</sup> Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээр үнэт цаасны зах зээлд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг "Юнайтед айр файненс" ХХК-д олгосон бөгөөд "Юнайтед айр файненс" ХХК нь 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдөр компанийн нэрээ өөрчилж "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК болгосон тул тусгай зөвшөөрөл нь "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хувьд хүчинтэй гэж үзнэ.

5183855  
9021031196 СТС2420



2024 -03 - 25

Хүснэгт 21. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл  
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга



X.Маргад-Эрдэнэ Гүйцэтгэх захирал	Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал X.Маргад-Эрдэнэ нь Монгол улсын Их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Тэрээр "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн үүсгэн байгуулагч ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал, Олон Улсын санхүүжилтээр 14 дэх жилдээ ажиллаж буй арвин туршлагатай мэргэжилтэн юм. МУЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн A-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Ж.Онон Партнер	Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн Партнер Ж.Онон нь Лондонгийн Эдийн засгийн Их сургуулийг банк, санхүүгийн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй төгссөн. Тэрээр "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн үүсгэн байгуулагч ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал, Олон Улсын санхүүжилтээр 14 дэх жилдээ ажиллаж буй арвин туршлагатай мэргэжилтэн юм. МУЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн A-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Б.Буяннэмэх Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал албан тушаалтай Б.Буяннэмэх нь Монгол улсын Их сургуулийг Эдийн засаг мэргэжлээр бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, багцын удирдлага, зээлийн шинжилгээ, үнэт цаасны чиглэлээр 10 дахь жилдээ ажиллаж байна. МУЦАЭХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бodoх бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан нийт 139.85 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж, есөн Тусгай зориулалтын компанийтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Эдгээр нээлттэй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь хугацааны дундуур борлуулах, дараагийн хөрөнгө оруулагчдад шилжүүлэх боломжтой хөрвөх чадвар бүхий бүтээгдэхүүнүүд юм.





2024 -03- 25

Ажиллаж буй төслийн мэдээлэл

БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга



№	ХБҮЦ гаргагч	Гаргасан огноо	Гаргасан дүн (тэрбум.төг)	ХБҮЦ-ны үлдэгдэл дүн (тэрбум.төг)	Хугацаа	Хэлцлийн зөвлөхөөр ажилласан эсэх
1	"Омни Актив ТЗК" ХХК	2022.03.04	5.00	2.50	24 сар	Үгүй
2	"Симпл Ассет ТЗК" ХХК	2022.06.23	50.00	0.00	18 сар	Тийм
3	"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК	2022.09.02	10.00	5.00	24 сар	Тийм
4	"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК	2022.10.18	10.00	5.00	24 сар	Тийм
5	"ЛэндМН Актив ТЗК" ХХК	2022.11.01	4.85	4.85	24 сар	Тийм
6	"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК	2022.12.19	10.00	5.00	24 сар	Үгүй
7	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.04.28	9.00	9.00	24 сар	Тийм
8	"Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК	2023.06.28	20.00	20.00	24 сар	Тийм
9	"Омни Ассет ТЗК" ХХК	2023.11.28	6.00*	6.00	24 сар	Тийм
Нийт			124.85	57.35		

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн вэбэд суурилсан няглан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн дэлгэрэнгүй нөхцөлийн талаар Хавсралт 8.8-аас үзнэ үү.

## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

Энэхүү гэрээг нэг талаас Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК болон Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Юу Эй Эф ассет менежмент" ХХК нар 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 24/795 дугаартай "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ"-г байгуулсан. Тус гэрээний зорилго нь ТЗК Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоостой Хөрөнгө итгэмжлэн удирдагч буюу Юу Эй Эф ассет менежмент ХХК-иас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, талуудын эрх үүргийг тодорхойлжээ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон няглан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх мэргэжилтнийг томилно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана. Мөн багцын хөрөнгөд багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг өөрчлөлтүүдийг оруулна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасны дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлбөр төлөх буюу төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна. Мөн Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн



2024 -03- 25


Үнэт цаасны танилцуулга



БҮРТГЭВ-02

төлбөрийн болон хүргүүлийн хэсгийн үлдэгдэл хэсгээр зөвшөөрөгдсөн хэрэнгэ оруулалтыг төгрөгөөр хийж болно.

ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон эсхүл, хэрэнгийн ашиглалт, нөөц хэрэнгийн талаар зөрчил гарвал энэ тухай нэн даруй ТЗК-д буюу ТЗК-ийн ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй.



### Хэрэнгэ итгэмжлэн удирдагчийг солих

- Хэрэнгэ итгэмжлэн удирдагч нь гэрээнд заасан зөрчил гаргасан эсхүл гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, үүргээ биелүүлэх шаардлага хүргүүлсэн боловч гаргасан зөрчлөө арилгаагүй, үүргээ гүйцэтгэхгүй нь тодорхой эсхүл үүргээ биелүүлэх чадваргүй болсон, дампуурах нөхцөл байдал бий болсон, хэрэнгэ итгэмжлэн удирдагчийг солих шаардлага үүссэн тохиолдолд гэрээг ТУЗ-ийн шийдвэрээр цуцална;
- Үнэт цаас гаргагч нь Хэрэнгэ итгэмжлэн удирдагчийг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журамд заасан үндэслэлээр солих тохиолдолд Хэрэнгэ итгэмжлэн удирдагчид ажлын 30 өдрийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 30 өдөрт багтаан Хэрэнгэ итгэмжлэн удирдагчид хадгалагдаж байсан ХБҮЦ-ны болон хэрэнгийн багцтай холбоотой баримт бичгийг Үнэт цаас гаргагчийн шинээр томилогдсон этгээдэд хүлээлгэн өгөх эрхтэй;
- Үнэт цаас гаргагч нь шинэ хэрэнгэ итгэмжлэн удирдагчийг сонгон, томилж амжаагүй тохиолдолд тийнхүү шинээр томилогдох хүртэл хугацаанд Хэрэнгэ итгэмжлэн удирдагч нь хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэвийн, урьдын адил гүйцэтгэх үүрэгтэй;
- Хэрэнгэ итгэмжлэн удирдагч нь шинээр томилогдсон Хэрэнгэ итгэмжлэн удирдагчид ажил хүлээлцэх актын дагуу ТЗК-тай холбоотой эзэмшиж байсан бүхий л мэдээлэл, баримт бичиг, данс тооцоо, бэлэн мөнгө, тайланг баримтаар болон цахимаар ямар нэгэн шимтгэлгүйгээр хүлээлгэн өгснөөр гэрээ цуцлагдсанд тооцно.

### Хэрэнгэ итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээг цуцлах нөхцөл

Үнэт цаас гаргагч Бичил Эй Би Эс Лояалти ТЗК ХХК нь Хэрэнгэ итгэмжлэн удирдагч Юу Эй Эф ассет менежмент ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан 24/795 дугаартай Хэрэнгэ итгэмжлэн удирдах гэрээнд зааснаар Хэрэнгэ итгэмжлэн удирдагчийг дараах тохиолдолд зөрчил гаргасанд тооцож, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд:

- Хэрэнгэ итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээг гэрээнд зааснаар гүйцэтгээгүй, гүйцэтгэхийг шаардсан хэдий ч зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй;
- Хэрэнгэ итгэмжлэн удирдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэт, зохих ёсны дагуу гүйцэтгээгүйн улмаас ХБҮЦ эзэмшигчид болон ТЗК-д шууд болон шууд бус хохирол учирсан;



2024-03-25

## Үнэт цаасны танилцуулга

EYPTReB-02

- Хөрөнгийн багцыг буруу удирдсан буюу хөрөнгийн багцад зохих өөрчлөлт оруулаагүйгээс ХБҮЦ-ны төлбөр хүрэлцэхгүй болсон, ХБҮЦ эзэмшигний хугацаандаа төлбөр хүлээн авах боломжгүй нөхцөлийг бий болгосон;
  - ХБҮЦ эзэмшигчид, эрх бүхий этгээдэд хүргэх мэдээллийг “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасан хугацаанд удаа дараа мэдээлээгүй.

Мөн Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27а/03 тоот тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журамд зааснаар хөрөнгө итгэмжлэн удирдагч нь журмаар тодорхойлсон шаардлага хангахгүй болсон нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болж байна.

ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлэхээр гэрээнд тусгасан байна.



2024 -03- 25

БҮРГЭЗБ-02

БИХ  
БҮРГЭЗБ  
БААНЫ АДАМ САЛВО  
БҮРГЭЗБ

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



# ДӨРӨВ. Үнэт цаасны тухай

## БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ

РХОГ  
ДКО  
АЧИГ

2024 -03- 25




Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

## 4.1. ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ

Бичил 3 ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд. Ахны үүрэг гүйцэтгүүлэгч "Бичил глобус финанс ББСБ" ХХК, Үндсэн андеррайтераар "Өлзий энд Ко капитал УЦК" ХХК, хөндлөнгийн хараат бус хуулийн дүгнэлт гаргагчаар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, зээлийн шинжилгээ гаргагчаар "Си Пи Ти Эй Аудит" ХХК, хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юу Эй Эф ассет менежмент" ХХК нар ажилласан. Үнэт цаасжуулах хэлцлийн ерөнхий зураглалыг доорх байдлаар дүрслэв.

Схем 6. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал



## ТЗК байгуулах

ТЗК нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулгаддаг, дүрэмд заасан үйл ажиллагааг эрхэлдэг, СЗХ-ны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дүгээр хэсэгт заасны дагуу Бичил глобус финанс ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор холбогдох хууль журмын дагуу "Бичил Эй Өлзий энд Ко капитал УЦК ХХК-ийг үүсгэн байгуулсан.



2024-03-25

Үнэт цаасны танилцуулга



БҮРТГЭВ-02

Үнэт цаасжуулах зээлийн (хөрөнгийн) багцыг сонгох

СЗХ

2024.03.25  
БҮРТГЭВ

Хөрөнгийн багцад ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгүүд багтсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нараар давхар баталгаажуулан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан хөрөнгийг ТЗК руу шилжүүлнэ.

**Багцад багтсан хөрөнгүүд шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд тэдгээр шалгуурын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээл нь шаардлага хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, зээлийн санхүүгийн шинжилгээг Си Пи Ти Эй Аудит ХХК тус тус боловсруулсан.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК руу хөрөнгө шилжүүлэх**

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/790 дугаартай "Хөрөнгө худалдах, худалдан авах" гэрээний дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-д шилжүүлэхээр харилцан тохиролцсон болно. Тус гэрээ нь нийт 15 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна.

**Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх**

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", Монголын хөрөнгийн биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, СЗХ, МХБ-д тус тус хүргүүлнэ. Эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаална.

**Анхдагч зах зээлийн захиалгыг зохион байгуулах**

СЗХ, МХБ-ээс зөвшөөрөл олгогдсоны дараа Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулж, МХБ-ээр дамжуулан анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авч, гүйцэтгэнэ.

**Хөрөнгө оруулагчид Бичил З ХБҮЦ худалдаж авах**

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нээгдэх хугацаанд бичил З ХБҮЦ үзэмших хүсэлтэй хөрөнгө оруулагчид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаасны дансандаа мөнгөө байршуулж, захиалгаа өгнө. Захиалга биелснээр



2024 -03- 25



БҮРТГЭВ-02

Үнэт цаас хөрөнгө оруулагчийн эзэмшилд шилжиж, үнэт цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүгийн болон үндсэн төлбөрийг хүлээж авна.

Үнэт цаасны танилцуулга

2024.03.20 өдөр  
ЭВ

## Хөрөнгийг удирдах

Хөрөнгө итгэмжлэн удирдагч ЮУ ЭЙ ЭФ Ассет Менежмент ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгөтэй холбоотой бүртгэх, тайлагнах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үнэт цаасны хугацааны турш үзүүлнэ.

## ТЗК татан буулгах

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдж дууссан буюу баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн, баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагч/худалдагч буцаан худалдан авсан тохиолдолд эсвэл баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлэгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан тохиолдолд ТЗК-г татан буулгана.

## 4.2. ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮГИЙН ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний шинж чанарын хувьд хадгаламж, Засгийн газрын үнэт цаас, компанийн нээлттэй болон Биржийн бус зах зээлийн хаалттай бондтой харьцуулах боломжтой юм. Бичил 3 ХБҮЦ-ны хүүг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, Монголбанкны макро эдийн засгийн төсөөлөл, банкнуудын хадгаламжийн өгөөж, сүүлд олон нийтэд нээлттэй гаргасан ижил төстэй үнэт цаасны өгөөжтэй харьцуулах байдлаар гаргасан.

Бичил 3 ХБҮЦ-ны хөрөнгө оруулалтын өгөөжийг зах зээл дээр хөрөнгө оруулагчдын хүлээлт, хөрөнгө оруулалтын боломжийг харгалзан үзэж 1.) Макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, инфляцын түвшнээс өндөр буюу мөнгөний бодит үнэ цэнийг алдагдуулахгүй байх, 2.) Банкны хугацаатай хадгаламжийн хүүгээс өндөр, 3.) Тогтмол өгөөжтэй үнэт цаасны хүүгийн түвшинтэй харьцуулахад өрсөлдөхүйц байхаар тогтоосон.

## ИНФЛЯЦЫН ТҮВШИНТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар улсын хэмжээнд инфляцын түвшин 7.9 хувь буюу өмнөх сараас 0.7 пунктээр буурч, сүүлийн гурван сар дарааллан нэг оронтой тоонд хадгалагдаж байна. Ийнхүү инфляцын түвшин саарч байгаа нь тогтмол өгөөжтэй үнэт цаасны нэрлэсэн хүүгийн түвшин буурах хүчин зүйл болж байгаа хэдий ч, нөгөө талд хөрөнгө оруулагчдын хүлээлт, тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь хүүгийн түвшин харьцангуй өндөр тогтох хүлээлт үүсгэж байна.



График 26. Инфляц ба бодлогын хүү



Эх сурвалж: УСХ

Бичил ЗХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт 18.5 хувийн хүүг санал болгож байгаа нь инфляцын түвшнээс 10.6 хувийн нэмэгдэл өгөөжтэй, бодлогын хүүтэй харьцуулахад 5.5 нэгжээр өндөр өгөөжтэй тогтсон байна.

## БАНКНЫ ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хугацаатай хадгаламжийн зарласан хүү дунджаар 12.2 хувь байна. Банкны системийн хэмжээнд шинээр татсан төгрөгийн, хугацаатай хадгаламжийн дундаж хүү 11.6 хувь байгаа бол валютаар шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүү 4.2 хувь байна.

График 27. Системийн нөлөө бүхий банкнуудын төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү



Эх сурвалж: Банкнуудын албан ёсны вэб хуудас

## НЭЭЛТТЭЙ БОНД БА ХБҮЦ-НЫ ХҮҮ

Монголын хөрөнгийн биржээр 2023 онд олон нийтэд нээлттэй хүрээнд 4 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 5 бонд амжилттай арилжаалагдсан байна. Олон нийтэд нээлттэй санал болгосон ХБҮЦ-ны дундаж хүү 18.0 хувь байгаа бөгөөд хамгийн суулд гарсан Омни ХБҮЦ 19.6 хувь, Бичил глобус 2.0 ХБҮЦ 18.5 хувь, ЛэндМН актив ХБҮЦ 17.0 хувь, Бэрс 3 ХБҮЦ 18.0 хувь байсан.

УЛСААН БАТААРЫН  
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ  
Олон нийтэд нээлттэй хүрээнд  
Хамгийн суулд гарсан Омни ХБҮЦ 19.6 хувь  
Бичил глобус 2.0 ХБҮЦ 18.5 хувь  
ЛэндМН актив ХБҮЦ 17.0 хувь  
Бэрс 3 ХБҮЦ 18.0 хувь байсан.



2024 -03- 25



Үнэт цаасны танилцуулга

График 28. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны жилийн өгөөж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Олон нийтэд нээлттэй санал болгож буй Бичил 3 ХБҮЦ нь 2022-2023 оны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дундаж хүүгийн түвшин 18.2 хувиас өндөр буюу 18.5 хувиийн өгөөжийг хөрөнгө оруулагч нарт санал болгож байна.

#### 4.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Бичил 3 ХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт үндсэн төлбөрийг ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш хагас жил тутамд нийт 4 удаа, тэнцүү хуваан төлөх нөхцөлтэй бол хүүгийн төлбөрийг улирал тутамд олгохоор шийдвэрлэсэн нь үнэт цаасны хөрвөх чадвар, дахин хөрөнгө оруулалт (reinvestment)-ын боломжийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 22. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр

Улирал	Анхны хөрөнгө оруулалт	Хүүгийн орлого (5% татварын дараах)	Үндсэн төлбөр хүлээн авах	Хүлээн авах нийт төлбөр
0	(1,000,000.0)	-	-	-
1	-	43,937.5	-	43,937.5
2	-	43,937.5	250,000.0	293,937.5
3	-	32,953.1	-	32,953.1
4	-	32,953.1	250,000.0	282,953.1
5	-	21,968.8	-	21,968.8
6	-	21,968.8	250,000.0	271,968.8
7	-	10,984.4	-	10,984.4
8	-	10,984.4	250,000.0	260,984.4
Нийт	(1,000,000.0)	219,687.5	1,000,000.0	1,219,687.5

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол (жишээ)

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь 1,000,000.0 (нэг сая) төгрөгөөр 10 ширхэг Бичил 3 ХБҮЦ-д хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд хугацааны эцэст буюу 24 сарын дараа татварын дараах байдлаар 22.0 хувиийн өгөөж буюу мөнгөн дүнгээр 219,687.5 төгрөгийн өгөөж хүртэхээр байна.



2024 -03 - 25

Үнэт цаасны танилцуулга



БҮРТГЭВЭР-02

## 4.4. ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

## ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ, АРГАЧЛАЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/03 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын дагуу үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг тооцож олгоно. Үүнд, анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс хүүг тооцож эхэлнэ. Үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийг дараах аргачлалын дагуу хөрөнгө оруулагчид олгоно.

Хүснэгт 23. Төлбөрийн хуваарь ба төлбөр тооцох аргачлал

Хүү тооцож эхлэх хугацаа	Анхдагч зах зээлийн захиалга явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш
Хүү төлөх давтамж	Улирал тутам
Хүүгийн төлбөр тооцох аргачлал (татварын өмнө)	Улирал тутам: $\frac{(\text{Тоо ширхэг} * \text{Тохируулагдсан нэрлэсэн үнэ}) * 18.5\%}{365} * \text{Хүү тооцох хоног}$ Тайлбар: Улирал тутам хүүгийн төлбөрийг олгоходоо анхны хөрөнгө оруулалтаас өмнөх хагас жил тутмын үндсэн төлбөрийг хассан дүн (тохируулагдсан нэрлэсэн үнэ)-ээс хүүг тооцно. Жилийн хүүг тооцох суурь хоног нь 365 хоног ба ХБҮЦ-ны хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш улирал тутмын, мөн өдөр төлнэ. Төлбөр төлөх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр шилжүүлнэ.
Хүүгийн төлбөр тооцох аргачлал (татварын дараа)	Улирал тутам: $\frac{(\text{Тоо ширхэг} * \text{Тохируулагдсан нэрлэсэн үнэ}) * 17.575\%}{365} * \text{Хүү тооцох хоног}$ ХБҮЦ-ны хөрөнгө оруулагч нь үнэт цаасны нийт хугацааны туршид 8 удаа хүүгийн төлбөр хүлээн авна.
Үндсэн төлбөр төлөх давтамж	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 сар тутмын мөн өдөр, анхны хөрөнгө оруулсан дүнг дөрвөн удаа хуваан, тэнцүү төлөлтөөр олгоно. Үндсэн төлбөр хийгдэх өдөр амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг шилжүүлнэ.
Үндсэн төлбөр тооцох аргачлал	Үндсэн төлбөрийг тооцоходоо хөрөнгө оруулагчийн анхдагч зах зээл дээрээс худалдан авсан нийт нэрлэсэн дүнг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сар тутамд, 4 удаа тэнцүү хуваан олгоно. Тус дүнгээс ХХОАТ тооцохгүй.
Нийт төлөгдхөн дүн	$\text{Үндсэн төлбөр} + \frac{\text{Хүү тооцох дүн} * 17.575\%}{365} * \text{Хүү тооцох хоног} * 8 \text{ удаа}$

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол



2024-03-25

Үнэт цаасны танилцуулга

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨХГҮЙ НӨХЦӨЛД АВАХ АРГА  
ХЭМЖЭЭ



Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина. Хэрэв Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ.

- Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Тус үүргийг ТЗК-тай байгуулсан "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.
- "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, Хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй гаргасан) зөрчлийн улмаас Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.
- Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг Үйлчилгээ үзүүлэгчээс шаардах, хяналт тавих эрхтэй. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу худалдан авах, 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон нийт 25,678,165,277 (хорин таван тэрбум зургаан зуун далан найман сая нэг зуун жаран таван мянга хоёр зуун далан долоо) төгрөгийн автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцаас орох мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн Бичил 3 ХБҮЦ-ны тухайд эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.



2024 -03- 25



БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

## СУЛ ЧӨЛӨӨТЭЙ ЭХ ҮҮСВЭРИЙН УДИРДЛАГА

Бичил Эй Би Эс Лояалти ТЗК ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/03 дугаарын тогтоолоор батлагдсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах журам”-ын дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр ТЗК-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрсдэл, өгөөж болон ХБҮЦ-ны холбогдох үүргийг гүйцэтгэхэд аливаа хүндрэл учрахгүй байх бүхий л бололцоог харгалзан тооцоо судалгаа хийсний үндсэн дээр дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулна.

Схем 7. Сул чөлөөтэй хөрөнгийг байршуулах боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслүүд



ХБҮЦ-ны төлбөрийг хугацаандаа төлөх боломжийг хангах зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын дуусах хугацааг ХБҮЦ-ны төлбөр төлөх хуваарьт өдрөөс ажлын 2 (хоёр)-оос доошгүй өдрийн өмнө дууссан байхаар тохируулсан байна.

## ТӨЛБӨРИЙН ДАРААЛАЛ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/03 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам”-ын 5.1-д заасны дагуу ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:

Схем 8. Төлбөрийн дараалал

1. ТЗК-ийн татварын төлбөр
2. ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар
3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой зардал
4. Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал
5. Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр
6. ТУЗ-ийн гишүүдийн цалин
7. ХБҮЦ-ны хүүгийн төлбөр
8. ХБҮЦ-ны үндсэн төлбөр
9. Бусад зардал





2024-03-25

EYPT103B-02

## Үнэт цаасны танилцуулга

ҮНЭТ ЦААСЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ОЛГОХООС ӨМНӨ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨР,  
ЗАРДЛЫН МЭДЭЭЛЭЛ

илцуулга  
2024.03.20  
год  
өдөр  
ТӨЛБӨР  
БИЛГИ  
ГЭВ  
1

Баталгаат үнэт цаас гаргах болон түүнийг бүртгүүлэхтэй холбоотой дараах зардлыг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгөөс төлөхгүй буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрийг нэхэмжлэхгүй болно. Үүнд: Андеррайтерийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийн багцын шинжилгээний аудитын тайлан болон хуулийн дүгнэлт гаргах үйлчилгээний төлбөр, маркетингийн зардал, Хороо болон МХБ-д бүртгүүлэхтэй холбоотой хураамж, ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой бусад маркетингийн зардлууд багтана.

## ТӨЛБӨРИЙН ГРАФИК

#### Хүснэгт 24. Төлбөрийн график, сая төгрөгөөр


Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол, (жишээ)

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 25,678,165,277.1 төгрөгийн дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгийн багцаас орж ирэх зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдэнэ. Тус зээлийн багцын үнийн дүн нь хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нийт татаан төвлөрүүлэх үнийн дунгээс 28.4 хувиар илүү байна.

#### 4.5. ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ

Бичил З ХБҮЦ-ны хөрөнгийн багцын хувьд Зээлийн шинжилгээ гаргагчийн тайландаа дурдсанын 2023 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон 1,484 зээлдэгчийн 25,678,165,277.1 төгрөгийн дүн бүхий зээлийн багцаас Санхүүгийн зээлийн шинжилгээ гаргагч “Си Пи Ти Эй Аудит” ХХК нь 125 зээлийг, хуулийн хөндлөнгийн шинжилгээ гаргагч “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН нь 53 зээлийг түүврийн аргаар сонгон авч зээлийн шинжилгээг гүйцэтгэн тайлан гаргасан. (Зээлийн шинжилгээ болон Хуулийн дүгнэлтийн дэлгэрэнгүй тайланг Хавсралтаас узнэ үү.)

Тус хөрөнгийн багцын жагсаалт дахь зээлийн барьцаа хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нэр дээр бүртгэлтэй бөгөөд аливаа үүрэгт давхар барьцаалаагүй, үүргээ бүрэн барагдуулж дуустал аливаа үүрэг гүйцэтгүүлэхээр давхар барьцаалахгүй байх талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу уусгэн



2024 -03- 25



БҮРЛГСВ-02

Үнэт цаасны танилцуулга

байгуулагчаас баталгаа өгсөн болно. (Энэхүү хөрөнгийн багц дахь зээлийн жагсаалт, холбогдох мэдэгдлийг Хавсралт 8.10-аас харна уу.)

Хүснэгт 25. Хөрөнгийн багцын үзүүлэлтүүдийн хураангуй

Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлтүүд	
Нийт зээлийн үлдэгдэл, төгрөг	25,678,165,277.1
Нийт анх олгосон дүн, төгрөг	28,547,305,000.0
Зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн, төгрөг	68,741,010,000.0
Зээлийн гэрээний тоо	1,484
Зээлдэгчийн тоо	1,484
Зээлийн дундаж үлдэгдэл, мянган төгрөг	17,303,345.9
Зээлийн төрөл	Автомашины фидуци бүхий зээл
Зээлийн төвлөрөл	
Хамгийн их дүнтэй 1 зээлийн нийт багцад эзлэх хувь	0.2%
Хамгийн их дүнтэй 10 зээлийн нийт багцад эзлэх хувь	1.7%
Хамгийн их дүнтэй 50 зээлийн нийт багцад эзлэх хувь	7.7%
Жигнэсэн дундаж үзүүлэлт	
Жигнэсэн дундаж хүү (сарын)	3.09%
Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа (сар)	41.5
Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа (сар)	33.5
Багцын зээлийн чанар	100% хэвийн зээл

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын мэдээлэл


## ХӨРӨНГИЙН БАГЦЫН ШАЛГУУР

Бичил ЗХБҮЦ-ны зээлийн багц нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан дараах хөрөнгийн багц, түүнд тавих шаардлагыг бүрэн хангасан байна.

Хүснэгт 26. Хуулийн шаардлагад нийцэж буй байдал

Хуулийн хэсэг, заалт	Хуулийн заалт	Хангагдсан эсэх
9.1 дэх хэсэг	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ.	<b>Тийм.</b> (Үнэт цаас гаргагчийн 20.0 тэрбум төгрөгийн дүнтэй үнэт цаас нь 25.6 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багцаар баталгаажсан.)
Монголын хөрөнгийн биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур шаардлага тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд Биржээс хяналт тавих журмыг тодорхойлсон байна.

## 5.2. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМУУД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24/27a/03 тоот тогтоолоор баталсан.

Хүснэгт 39. Үнэт цаас гаргагчтай холбоотой дүрэм, журмууд

Журам	Хураангуй тодорхойлолт
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх журам	Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.
Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам	Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.






/004-00-13

БҮРТГЭВ 02

## Үнэт цаасны танилцуулга



Хөндлөнгийн аудитор, Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам	Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.
Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам	Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас буюу ХБҮЦ гаргахтай холбоотойгоор байгуулагдсан ТҮЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан.
Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам	Тус журмаар ТЗК-аас гаргах Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд ХБҮЦ-ны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.
Хөрөнгө итгэмжлэн удирдах журам	Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.
Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам	Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, ХБҮЦ-ны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан.





ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



# ЗУРГАА. Үнэт цаасны арилжаа

## БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ





Үнэт цаасны танилцуулга



## 6.1. ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1 болон 12.2-т Санхүүгийн зохицуулах хорооны олон нийтэд санал болгохыг хүлээн зөвшөөрсөн, мөн Монголын хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлээр арилжихыг заасан байдаг.

Улмаар Бичил 3 ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" (2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 9 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан), мөн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д (ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн №05 тогтоолоор өөрчлөлт оруулсан) заасны дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн "ХБҮЦ-ны бүртгэлийн журам"-д заасан шалгуурын дагуу "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд ХБҮЦ-ыг санал болгон арилжаална. Тус үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болно. Бичил 3 ХБҮЦ-ыг ангилалтай гаргахгүй бөгөөд тус баталгаат үнэт цаасыг хөтөлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдахгүй.

Бичил 3 ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд явуулах ба захиалгын дүн татан төвлөрүүлэх хөрөнгийн 100.0 хувьд хүрсэн тохиолдолд арилжааг амжилттай болсонд тооцож, анхдагч зах зээлийн арилжааг хаана. Олон нийтэд танилцуулах, сурталчлах болон ХБҮЦ-ны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд дараах үйл явцын дагуу санал болгоно.

Схем 13. Анхдагч зах зээлийн арилжааны үйл явц



Олон нийтэд мэдээлэх аян (roadshow)-ыг ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулах ба анхдагч зах зээлийн захиалгыг ажлын 5 өдөрт бүрэн бүрдүүлж, захиалгыг хаана.

## 6.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд СЗХ-ноос зөвшөөрөл авсан Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компанийар дамжуулан оролцох боломжтой.





2024-03-25

Үнэт цаасны танилцуулга

9024-03-25  
БИРЖ ГЭЭД  
БААНЫ САЛОН

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандадаа байршуулах боломжтой. Хэрэв үнэт цаасны дансгүй бол Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдгийг та тооцно уу.

- Дурын банкнаас бонд авах мөнгөн дүнг дараах зааврын дагуу байршуулаад өөрийн үйлчлүүлдэг брокерийн компанийн аппликацийн ашиглан захиалгаа оруулах эсхүл брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.

Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Дансны нэр: Таны өөрийн нэр

Дансны дугаар: \*\*\*\* \* (өөрийн брокероос лавлах)

Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

- Дурын данснаас өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн номинал дансанд байршуулаад цахимаар болон утсаар захиалгаа баталгаажуулах боломжтой.

Банкны нэр: УЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр

Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр

Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар

Гүйлгээний утга: регистрийн дугаар

## ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

ХБҮЦ-ыг олон нийтэд нээлттэй санал болгох үйл ажиллагаа амжилттай болсон тохиолдолд, МХБ-ын холбогдох журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр тус үнэт цаасыг эзэмшигч нь хоёрдогч зах зээл дээр бусдад чөлөөтэй худалдах, бусдаас худалдан авах эрхтэй байна.

### 6.3. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас эзэмшигч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны гэрээнд заасны дагуу дараах эрхтэй байна. Үүнд:

- ХБҮЦ-ыг Монголын хөрөнгийн биржийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Эзэмшигч буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- ХБҮЦ эзэмшигч буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүрээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;



103

5183855 CTC2420

9021031195

2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга

2024.03.20  
өдөр  
ГГЭВ  
11

- Үнэт цаас эзэмшигчийн ХБҮЦ-ыг МХБ-ээр дамжуулан худалдах захиалгаа хэдийд ч брокертоо өгөх эрхтэй бөгөөд уг захиалгыг биелүүлэхэд андеррайтер нь дээд хүчин чармайлт (the best-effort) гаргасан боловч зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн орчноос шалтгаалан захиалга биелэхгүй 45 хоног өнгөрсөн бол Үнэт цаас гаргагчаас эзэмшиж буй ХБҮЦ-аа зах зээлийн ханшаар эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй. Тус тохиолдолд худалдах үнийг брокер болон Үнэт цаас гаргагч нар нь харилцан тохиролцож, арилжааны шимтгэл зэрэг зардлуудыг харгалzan үзэж тогтооно.
- Хууль тогтоомжид заасан бусад.

#### Албан татварын тухай

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдох бусад зардлыг хассан дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5.0 хувийн татвар төлнө. Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн 18.6.3-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсан, шилжүүлсэн үнээс худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, энэхүү дүнгээс тус хуулийн 20.2.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

#### 6.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

ТЗК нь хөрөнгийн өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй.

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган, үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, ногдох татварыг төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх журам"-д заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Үнэт цаас эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг эргүүлэн худалдаж авахыг шаардсан тохиолдолд уг шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

#### 6.5. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ





2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга

2024. 03. 20. өдөр

ХҮРГЭВ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй.

Мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”, МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам” болон ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан “Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам”-д заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээллүүдийг үнэт цаас эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Үнэт цаас гаргагчийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь ТЗК нь татан буугдах хүртэл хугацаанд байршина.

## ХУГАЦААНЫ ТОГТМОЛ ДАВТАМЖТАЙ ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ

### Өөрчлөлт гарсан тохиолдолд хүргүүлэх мэдээлэл

ТЗК нь дараах мэдээлэлд өөрчлөлт орсон бол дараа сарын 10-ны өдрийн дотор Хороо болон хөрөнгө оруулагчид мэдээлнэ.

- Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт;
- Хөрөнгийн багцын мэдээлэл, тэдгээрийн шинж байдал;
- Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ;
- Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон зээлийн харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, үндсэн төлбөр, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;
- Санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн тайлан;
- Хууль тогтоомж, энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд албан бичгээр ирүүлэх мэдээллүүд:

- ТЗК нь хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн дарга, гишүүдэд өөрчлөлт оруулсан бол энэ тухай Хороонд ажлын гурван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэх;
- ТЗК нь баталгаат үнэт цаасыг нийтэд санал болгон нээлттэй хүрээнд худалдах ажиллагааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулсанас үл хамааран олон нийтэд танилцуулах, сурталчлах, захиалга авах, хуваарилах


БИЧИН  
ЭЙН  
СОЯЛ  
ТЗК  
ATA112324 841986K  
9024010402

6183855  
9024010402  
105



2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга



хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд албан бичгээр мэдэгдэх;


- ТЗК нь баталгаат үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдаж, үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд хүргүүлэх.

Мөн ТЗК-ийн дүрэмд зөвхөн Хорооны зөвшөөрөл өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн өрөнхий газарт бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдэгдэх үүрэгтэй.

Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан Монголын хөрөнгийн биржид ирүүлэх мэдээллүүд:

- Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн, хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай;
- Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох;
- Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ийг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл;
- Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10.0 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5.0 хувиар өөрчлөгдөх тутамд;
- ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох;
- Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах;
- Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр;
- Барьцаат үнэт цаас гаргагчийн хувьд шинээр үнэт цаас гаргахтай холбоотойгоор барьцаа, баталгаа гаргах;
- ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох;
- Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл;
- Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай;
- Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд;
- Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл.

5183855  
8021001195 СТОС420 106



Үнэт цаасны танилцуулга



## Хагас жил тутам хүргүүлэх мэдээлэл

СЗХ болон МХБ-д бичгээр хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ. Тус мэдээллийг Хороонд хүргүүлэхдээ цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлэх бөгөөд дараах мэдээлүүд багтсан байна.

- Хөрөнгийн багцын үлдэгдэл;
- Хугацаандaa болон хугацаа хэтэрч төлөгдсэн үндсэн төлбөрийн хэмжээ;
- Хугацаанаасаа өмнө төлөгдсэн үндсэн төлбөрийн хэмжээ;
- Ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл;
- Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл.

Мөн багцын хөрөнгө, мөнгөн урсгалын хөдөлгөөн, үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргүүлсэн улирал тутмын тайлан, мэдээллийг МХБ-д дараа сарын 20-ны өдрийн дотор мэдээлнэ.

## Жил тутам хүргүүлэх мэдээлэл

ТЗК нь жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид дараа оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор СЗХ, хөрөнгө оруулагчдад болон Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ. Энэхүү мэдээллийг Хороонд хүргүүлэхдээ цахим болон хэвлэмэл хэлбэрээр мэдээлэх үүрэгтэй.

Үүнд дараах мэдээлэл багтсан байна.

- ТЗК-ийн болон түүний үүсгэн байгуулагчийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт;
- Үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хөрөнгө итгэмжлэн удирдагч этгээдийн тайлан;
- Хөрөнгийн багцад бүртгэгдсэн хөрөнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний үүрэг хүлээсэн үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагчийн сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл;
- ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Дээрх мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр давхар хүргэж болно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

СҮРТГЭВ-02

СЭХН  
ОХОНДААН  
БҮРГЭЭВ  
НЬ 31

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



ДОЛОО. Үнэт цаас  
гаргахад оролцсон  
байгууллагуудын тухай

# БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ





## 7.1. АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

БИРГЭЭ-02

2024.08.20 оны  
ӨҮРТГЭВ  
№01

Байгууллагын нэр	"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ УЦК" ХХК
Үйл ажиллагааны чиглэл	Андеррайтер, брокер, дилер, номинал дансны үйл ажиллагаа
Үүсгэн байгуулагдсан огноо	2007.12.06
Регистрийн дугаар	5183855
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506
Утас	+976 7777-6377
Цахим шуудан	<a href="mailto:info@ucc.mn">info@ucc.mn</a>
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Симпл аксет ХБҮЦ, ЛэндМН актив ХБҮЦ, Бичил 2 ХБҮЦ

Өлзий энд Ко капитал УЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал УЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч наарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, Нью-Йоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

- |         |   |
|---------|---|
| 2023 он | "Инновэйшн инвестмент" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер  |
| 2023 он | "ЛэндМН" Бонд-д Туслах андеррайтер  |
| 2023 он | "Хасбанк IPO"-д Хамтрагч андеррайтер  |
| 2023 он | "Бичил 2.0" ХБҮЦ-д Үндсэн андеррайтер   |
| 2023 он | "БИД нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер  |
| 2023 он | "Сэндли нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер   |
| 2023 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Үйзэн-Ивээлт ББСБ" ХХК-ийн хаалттай бондын Үндсэн андеррайтер                                      |
| 2022 он | "ЛэндМН" ХБҮЦ-д Хамтрагч андеррайтер  |
| 2022 он | "Төрийн банк" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох эхлэлийг тавьсан. |
| 2022 он | "Сэндли ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер   |
| 2022 он | "Симпл аксет" ТЗК-ийн ХБҮЦ-д Үндсэн андеррайтер   |

2022 он

УЛААНБААТАР ХАРЧ

БИЧИЛ ЭН БИД ГОДИЙН ТЭРХИМ

ATA11232 1419868

9024010482

УЛААНБААТАР ХАРЧ  
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ УЦК  
ХХК №01  
5183855  
9021031195 CTC2420

2024 - 03 - 25

Үнэт цаасны танилцуулга



2022 он	МУОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд Хамтрагч компани
2022 он	Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Ашид капитал ББСБ" ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер
2021 он	Биржийн бус зах зээлийн (OTC)-ийн анхны "БИД" бондын Үндсэн андеррайтер
2021 он	Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан "sandbox" төслийн анхны бүтээгдэхүүн болох "Монпэй" дижитал бондын Үндсэн андеррайтер
2021 он	Биржийн бус зах зээл (OTC)-ийн анхны гишүүн байгууллага
2020 он	Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер
2020 он	МУОНТ-н "Цагийн хүрдийн баатар"
2020 он	Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн "ЛэндМН" ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер
2019 он	"Ард Кредит ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.
2019-2020 он	Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 УЦК-д багтсан.
2018 он	Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шилдэг Мэргэжилтэн"

#### Өнөөгийн байдлаар "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ УЦК" нь:

"Мобифинанс ББСБ", "М-Си-Эс Инвестмент" ХХК, "Капитрон банк", "Ай Си Ти групп", "Сүү ХК", "Төрийн банк", "БИД ББСБ", "Ашид капитал ББСБ", "Монголчех Метал", "ОНДО", "Монголын финтек групп", "Эрхэт Монгол групп", "Бичил глобус финанс ББСБ" гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 333.2 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.



2024 -03 - 25

Үнэт цаасны танилцуулга

## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

2024.03.25

он сер өдөр  
БҮРТГЭВ

"Өлзий энд Ко капитал УЦК" ХХК нь Бичил Эй Би Эс Лояалти ТЗК ХХК, Бичийн глобус финанс ББСБ ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр №АГ-24/01 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээнд Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн дараах эрх, үүргийг тодорхойлсон. Үүнд:

- Андеррайтер нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн Бүртгэлийн журам болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах;
- Андеррайтер нь гэрээ болон ажлын төлөвлөгөөнд заасан ажил, үүргээ зохих ёсоор шударгаар биелүүлэх үүрэгтэй бөгөөд Андеррайтер нь төлөвлөгөөнд заасан ажил, үүргийг тогтсон хугацаанд нь гүйцэтгэх;
- Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн аливаа дотоод мэдээлэл болон нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр санаатай болон санамсаргүй байдлаар задруулахгүй, дамжуулахгүй байх, мөн түүнчлэн гуравдагч этгээд тэдгээр мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай харилцаж, Үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтан, мэргэжилтэнг томилон ажиллуулах ба тэдгээр ажилтан, мэргэжилтэн нартай Андеррайтераас өгсөн удирдамжийн дагуу холбогдох холбогдох ажил үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадаагүй тохиолдолд түүнийг солих шаардлагыг Андеррайтерийн зүгээс тавьж болох бөгөөд Үнэт цаас гаргагч энэхүү шаардлагыг биелүүлэх;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг гэрээнд заасан болон Андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах;
- Хэрэв Үнэт цаас гаргагч нь тогтоосон хугацаанд аливаа дотоод мэдээллийг Андеррайтертай зөвшилцэлгүйгээр олон нийтэд мэдээлсаэн, түүний улмаас Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэлгээнд эрс өөрчлөлт гарсан, хөрөнгө оруулалт, санхүүжилт татах ажиллагаанд саад учруулсан, хөрөнгө оруулагчдад буруу мэдээлэл хүргэсэн болон бусад байдлаар Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулсан бол Үнэт цаас гаргагч учирсан хохирлыг өөрөө хариуцах;
- Гэрээг хэрэгжүүлэх явцад Андеррайтераас Үнэт цаас гаргачид хүргүүлсэн нийтэд ил болоогүй бүх төрлийн мэдээлэл, зөвлөмж, тайлан мэдээ, төсөл төлөвлөгөөний загвар, агуулга, мэдээлэл зэргийг Үнэт цаас гаргагч нь зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд, Үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангахад ашиглах, Андеррайтерийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх.





## 7.2. ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

Байгууллагын нэр	"ЮУ ЭЙ ЭФ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК
Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа
Үүсгэн байгуулагдсан огноо	2021.09.16
Регистрийн дугаар	2870657
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын төв өргөө, 10 давхар, 1005 тоот
Утас	+976 7012-2346
Цахим шуудан	<a href="mailto:info@uaf.mn">info@uaf.mn</a>
ХБҮЦ дээр ажилласан туршлага	Омни актив ХБҮЦ, Симпл ассет ХБҮЦ, Бээрс ХБҮЦ, Нэмэр кредит ассет ХБҮЦ, ЛэндМН актив ХБҮЦ, Бичил Глобус ХБҮЦ, Бээрс 2 ХБҮЦ, Бичил 2 ХБҮЦ, Бээрс 3 ХБҮЦ, Омни ассет ХБҮЦ



Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох Юу Эй Эф Ассет Менежмент ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай. Компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг хүргэн ажилладаг. Компани нь компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн 100 хувь хараат бус төлөөлөн удирдах зөвлөлтэй.

Юу Эй Эф ассет менежмент ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар банк, банк бус санхүүгийн байгууллага, Орон сууцны санхүүжилтийн компани болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын Тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Компани нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй гаргасан нийт 139.85 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үүргийг гүйцэтгэж, есөн Тусгай зориулалтын компанийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа бөгөөд нэг Тусгай зориулалтын компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэлцлийг амжилттай гүйцэтгэж дуусгаад байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь одоогоор "Омни Актив ТЗК" ХХК 2.5 тэрбум төгрөг, "Бээрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК 5.0 тэрбум төгрөг, "Нэмэр Кредит Ассет ТЗК" ХХК 5.0 тэрбум төгрөг, "ЛэндМН Актив ТЗК" ХХК 4.85 тэрбум төгрөг, "Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК 5.0 тэрбум төгрөг, "Бээрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн 9.0 тэрбум төгрөг, "Бичил Эй Би Эс Плас ТЗК" ХХК 20.0 тэрбум төгрөг, "Омни Ассет ТЗК" ХХК 6.0 тэрбум төгрөг, "Бээрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК 15.0 тэрбум төгрөгийн хөрөнгө итгэмжлэн удирдаж байна.





МОНГОЛЫН ЗӨВХӨРӨГЧИЙН НАМЖ  
МОНГОЛЫН СҮХБАТЫН БҮСЭНЧИЙСЭН

2024-03-25

Үнэт цаасны танилцуулга

СЗХ  
2024-03-20 өдөр  
БҮРГЭС

## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

Нэг талаас "Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх), түүнийг төлөөлж ТУЗ-ийн дарга Н.Гантулга, нөгөө талаас СЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №473 тогтоолоор олгосон Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах ТЗ 316/18 дугаар тусгай зөвшөөрөлтэй "Юу Эф Ассет Менежмент" ХХК (цаашид "Хөрөнгө итгэмжлэн удирдагч" гэх), түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Х.Маргад-Эрдэнэ нар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлүүдийг тус тус удиртгал болгон сайн дурын үндсэн дээр 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 24/795 дугаартай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулсан.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хариуцах мэргэжилтнийг томилно. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмшиж удирдана;
- Хөрөнгийн багцад хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг өөрчлөлтүүдийг оруулна;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү гэрээнд заасны төлбөр цуглуулах дансны хуулга авах, үлдэгдэл шалгах эрхтэй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөр цуглуулах дансанд шилжүүлсэн хөрөнгийн багцын эргэн төлөлтийн дүнг зээлийн данс бүртгэлтэй тулган бүртгэж, баталгаажуулна;
- Төлбөр цуглуулах дансан дахь үндсэн төлбөрийн болон хүүгийн хэсгийн үлдэгдэл хэсгээр зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно;
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний хөлсийг төлбөр төлөх өдрөөс 10 ба түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээг Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ.





## 7.3. ЗЭЭЛИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Байгууллагын нэр	"Си Пи Ти Эй Аудит" ХХК
Үйл ажиллагааны чиглэл	Аудит, баталгаажуулалтын үйлчилгээ
Үүсгэн байгуулагдсан огноо	2011
Регистрийн дугаар	5530121
Хаяг	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв, 5 давхар, 501 тоот
Утас	(+976) 7723-3030
Цахим шуудан	<a href="mailto:info@cptaaudit.mn">info@cptaaudit.mn</a>
ХБҮЦ дээр ажилласан туршлага	-

Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК нь 2011 онд нягтлан бодох бүртгэл болон татварын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдаж, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн бол 2023 оны байдлаар тус компани нь 15 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс давхардсан тоогоор Монголын мэргэшсэн нягтлан бодогч 9, Аудитор 5, Монголын татварын мэргэшсэн зөвлөх 5, Гэрээний мэргэжилтэн 2, Туслах аудитор 5 гэсэн хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус компанийн гүйцэтгэх захирлаар Ч.Энхчимэг аудитор хариуцан ажилладаг.

"Си Пи Ти Эй Аудит" ХХК нь санхүүгийн тайлангийн аудитыг Монгол Улсын аудитын тухай хууль болон Аудитын Олон Улсын стандартын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэж ирсэн арвин туршлагатай юм. Үндсэн үйл ажиллагааны чиглэл болох аудит, баталгаажуулалтын хүрээнд аж ахуй нэгжийн санхүүгийн тайлангийн аудит, Санхүүгийн тайлангийн бүрдэл хэсгийн аудит, Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт, Аж ахуйн нэгжийн дотоод аудит гэсэн үйлчилгээг хүргэж байна.

Зээлийн шинжилгээ гаргагч нь дараах салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд Аудит болон бусад үйлчилгээ үзүүлж байна.

- Төрийн захиргаа удирдлага, төрийн үйлчилгээний байгууллага
- Уул уурхайн олборлолт болон хайгуул
- Олон нийтийн байгууллага
- Жижиглэн болон бөөний худалдаа, соёл урлаг
- Банк санхүү, хадгаламж зээлийн хоршоо
- Харилцаа холбоо, сургууль цэцэрлэг
- Эрчим хүчний үйлдвэрлэл, барилга
- Төрийн өмчийн болон хувийн эмнэлгүүд

## ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

Аудитын үйлчилгээ үзүүлэх зорилгоор, нэг талаас "Бичил глобус финанс ББСБ" ХХК (цаашид "Үйлчлүүлэгч" гэх), нөгөө талаас "Си Пи Ти Эй Аудит" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх) бөгөөд Үйлчилгээ үзүүлэх гэрээнд харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр Үйлчлүүлэгчийн худалдах зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ байгуулж, талуудын эрх, үүргийг доорх нөхцөлөөр тусгасан.

УЛААНБААТАР ХОТ

- Гүйцэтгэгч нь шинжилгээний тайланд шинжилгээ хийж тайлан дүргэжээ
- БН гаргахдаа Монгол Улсын Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай

АТА/11232-8419868  
9024010482

ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ ЦСК  
ХХК  
6183855  
9021031196 СТС2420114



2024-04-25

## Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журам, заавар Олон Улсын стандарт 4400 "Харилцан тохиролцсон ажил үйлчилгээ", компанийн дотоод стандарт, бодлого, журам, горим аргачлалыг үндэслэн. Санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүдийг нотлох баримтуудаар шалган, удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон гол чухал тооцооллуудыг үнэлж, аудитын явцад илэрсэн дотоод хяналтын сул тал ба материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдуудын талаар тайлан бичиж дүгнэлт өгнө;

- Аудитын байгууллага нь аудитын стандартын дагуу дотоод хяналтын бүтэц болон хүмүүст асуулга тавьж, судалгаа хийх ба мэдээ баримтыг биечлэн үзэх, нэмэлт материал, тайлбарыг гаргуулан авах эрхтэй. Эдгээр нь тайлан, дүгнэлт гаргахад туслах болно;
- Үйлчилгээний гүйцэтгэлийн явцад Аудитор нь Үйлчлүүлэгчтэй зөвлөлдөх, эсвэл тэдний саналыг тусгахын тулд тайлангаа үзүүлж болно. Ингэхдээ Харилцагч нь урьдчилсан тайлан болоод аман тайлбар болон зөвлөгөөнд түшиглэхгүй гэсэн үндсэн дээр хийгдэнэ. Тиймээс хэрэв Харилцагч урьдчилсан тайлан болоод аман тайлбар болон зөвлөгөөний үндсэн дээр үйлдэл хийх эсвэл үйлдэл хийхээс түдгэлзвэл Аудитор хариуцлага хүлээхгүй. Мөн Харилцагчид тайлангийн электрон хуулбарыг бэлтгэн өгч болно. Санал зөрлөсөн тохиолдолд гарын үсэг зурсан сүүлийн тайлангийн дагуу шийдвэрлэнэ;
- Аудитын байгууллага нь дотоод хяналтын бүтцийн ерөнхий үр нөлөөний талаар тусдаа дүгнэлт хийхгүй болно. Аудитор мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан болно;
- Үйлчлүүлэгч нь Аудиторыг үндэслэл бүхий тоног төхөөрөмжөөр хангах болон Үйлчлүүлэгчийн нэгдлийн мэдээ, мэдээлэлд тухай бүр нэвтэрч, ажилтнуудтай уулзах явдлыг хангах зэргийг оруулах (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) Аудиторыг Үйлчилгээ хийж гүйцэтгэхэд Аудитортой хамтран ажиллана. Үйлчлүүлэгч нь өөрийн ажилтнууд болон агентуудын гүйцэтгэл, Харилцагчийн нэгдэл буюу түүний нэрийн өмнөөс Аудитор-д гаргаж өгсөн бүхий л мэдээ, мэдээллийн (санхүүгийн бүх мэдээлэл болон тайланг оруулан) хамрах хугацаа, үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэд байдал, мөн Үйлчилгээний нэг хэсэг болгож өгсөн аливаа зөвлөгөөний хэрэгжилтийг тус тус хариуцна;
- Аудитор нь Харилцагчийн, эсвэл бусдын бэлдэж өгсөн мэдээ, мэдээлэлд баталгаажуулалтгүйгээр найдаж, ашиглаж болно. Аудиторын гүйцэтгэл нь Харилцагч хариуцлагаа тухай бүр хэрэгжүүлэх болон Үйлчилгээтэй холбогдуулан тухай бүр шийдвэр, зөвшөөрөл гаргах байдлаас хамаарна;
- Үйлчлүүлэгч нь Гүйцэтгэгчийн ажлын чанар, шударга зарчимч байдал, голч төлөв хандлагад хяналт тавих эрхтэй;
- Шинжилгээний тайлан гаргахтай холбогдсон зээлийн баримт бичиг, өөрийн байгууллагын онцлог, няглан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын журам, үйл ажиллагаа явуулдаг горимоо Үйлчлүүлэгчийн зүгээс Гүйцэтгэгчийн хүсэлт, шаардлага, зөвлөмжийн дагуу үзүүлж, тайлбарлан танилцуулах үүрэгтэй.





2024-03-25

Үнэт цаасны танилцуулга

## 7.4. ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Байгууллагын нэр	"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө өгөх
Үүсгэн байгуулагдсан огноо	2011
Регистрийн дугаар	5495997
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас	+976 11 330048
Цахим шуудан	<a href="mailto:info@mdsa.mn">info@mdsa.mn</a>
ХБҮЦ дээр ажилласан туршлага	ЛэндМН актив ХБҮЦ, Бэрс ХБҮЦ, Инвеккор актив ХБҮЦ, МИК актив 1-13,21,23,24,28,29, Бичил 2 ХБҮЦ, Бэрс 3 ХБҮЦ

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг. "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал,

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 3 удаа бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах;
- "Инвеккор ББСБ" ХК-ийн IPO, нэмэлт хувьцаа, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах;
- "Түмэн шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах;
- Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах;
- "Сэндли ББСБ" ХК-ийн IPO, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах;
- "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 3 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;
- "Төрийн банк" ХК-ийн IPO;
- "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн IPO;
- "Ай си рэйт" ХХК-ийн биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргах;
- "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох;
- "Инновэйшн Инвестмент" ХХКийн IPO;



2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга



БҮРТГЭВН-02

03Х  
2024 03. 20  
БҮРТГЭВН-01

- “Инвекскор Глобал Кью-Хамтын биржээр арилжаалагддаг ХОС”-д хуулийн зөвлөхөөр ажилласан зэрэг үнэт цаасны зах зээлд санхүүгийн хэрэгсэл гаргахтай холбоотой дурдсан туршлагын хүрээнд хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн болно.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН”-ийг “2021, 2022 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм”-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байдаг.

## ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ

“Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН (цаашид “Хуулийн зөвлөх” гэх) нь Гэрээгээр тохиролцсон хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээг Бичил глобус финанс ББСБ ХХК (цаашид “Үйлчлүүлэгч” гэх)-д үзүүлэх, Үйлчлүүлэгч нь тохиролцсон хөлсийг Хуулийн зөвлөхөд төлөхтэй холбоотойгоор Талууд “Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулж, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагатай холбогdon үүсэх дараах харилцааг зохицуулсан байна.

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх;
- Хуулийн зөвлөх нь шаардлагатай тохиолдолд өөрийн гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлтийн талаар хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллага болон бусад этгээдийн өмнө шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх үүрэгтэй;
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;
- Хуулийн зөвлөх нь Гэрээнд заасан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүрд шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үйлчлүүлэгчээс шаардан авах эрхтэй;
- Үйлчлүүлэгч нь Гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээ мэдээлэл, баримт бичгээр Хуулийн зөвлөхийг хангах, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах байраар хангах үүрэгтэй;
- Үйлчлүүлэгч нь гэрээнд заасны дагуу үнэн бодит мэдээллээр хангах, Хуулийн зөвлөхийн нууцыг чандлан хадгалах, Гэрээгээр харилцан тохирсон хугацаанд ажлын хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй;
- Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд үйлчилгээний талаар шаардлага тавих, санал гаргах эрхтэй.





7.5. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН  
ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч "Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Бичил глобус финанс ББСБ" ХХК нарт холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй бөгөөд тэдгээртэй аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэгч "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК;
- Зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК;
- Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН;
- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Өлзий энд Ко капитал УЦК" ХХК;

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх албан бичгүүдийг Хавсралт 8.13-аас харна уу.





ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

АНДЕРРАЙТЕР:



## НАЙМ. Хавсралт

# БИЧИЛ 3.0

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

20 ТЭРБУМ







# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

БУРТГЗВ-02

## Үнэт цаасны танилцуулга

Хуутшины эзгээдлийн үүсгэх байгуулалтад берилж бичихт оруулсан нийцэлтэй ферчлалтнийн бурдлагыг



Энэхүү тэршүүлэгч хуурынчаар үйлсэн төгрөгийн Монгол Улсын хуулийн залгуулжарин шалтгааг хүлээндэгэнэ. Улсын бүртгэлтэй тэршүүлэгчийн засваргтай бол хүчинчтүүлж, түүнийн төгрөгийн

000292360





2024 -03- 25

Үнэт цаасны танилцуулга

8.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭ

ТЗ 315/63

Дугаар

2023 оны 12 сарын 22 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай  
хууль Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад  
холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн  
зохицуулах хорооны 2023 оны 12 сарын 22 өдрийн 779 дугаар тогтоолоор  
“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК

Хөрөнгөөр баталгавжсан үнэт цаас гаргах

-д

ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

БАЯРСАЙХАН

Энэхүү горчилгоо нь  
хөвсргэлтийн хамт күчинтэй

БИЧИЛ  
ЭЙ БИ ЭС  
ЛОЯЛТИ  
ТЗК  
ХХК

АТААГДЫЧ 8419868  
0010482

УЛААНБАATAR ДОТ

ӨЛЗИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УЦК  
ХХК

СТС2420

122



# МОНГОЛ УЛС САНХУУГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

## Үнэт цаасны танилцуулга



Густай төвшөөрөг бүхий хувьтамшиг түүхэд зориуласан гэмргүйнүүд

PDF-XChange 软件截图 - 免费 PDF 编辑器

ХОЕР ХУШИН ТӨГӨЛЧИЙН АМГИДАА

ГУРАВ. Убийства ваны геральдеб юрий тимурдин

ТЗ 315/63 тоот  
ТУСТАЙ ЗӨВШОӨГЛИЙН  
ГОРЧИЦГЭЭНИЙ ХАВСРАЭЛ

130

“БИЧІЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЗК” ХХК

ҮЙЛ ЦАЛСЫН ТАХ ТЭРЭГ ТӨХИҮҮЛЭЛТАЙ ҮЙЛ АЖЫЛЛАГАА





# МОНГОЛЫН ХЕРЭНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

2024-03-25

EXPT-2-B-02

## Үнэт цаасны танилцуулга

**Дороги! Думайте о том, какими чистыми должны быть ваши автомобили!**

## ТАБ Хувь шийгүүдэс жүжигчийн төрөлжилтийн түвшнээс





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

**БУРТГЭВ-02**

БҮРЛАА Хувьцаа тэмшгүүийн газар

## Үнэт цаасны танилцуулга

2024.03.20 өдөр  
ҮҮРГҮЭВ





# МОНГОЛЫН ХБРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

2024 -03- 25

## Үнэт цаасны танилцуулга

38 X

7724 · 03 · 70

• 1 РТГЭВ

No. 11

ДО 100 НАЧАЛОВ ПОДДЕРЖИВАЮЩИХ ПРИЛОЖЕНИЯ К АКТУАЛІЗАЦІЇ

УДААНБААТАР ХОТ

106 XXX

ATA11232 8419868  
9024010482

УЛДАНБААТАР ХОТ

ӨЛЗНИЙ ЭНД КО  
КАПИТАЛ УЦК  
ХХК

**XXX**  
~~Alvin H. Adams~~  
SAC-BE  
90-03198 LTCM-JUL  
FBI

2024 -03- 25

БҮРТГЭВ-02


Үнэт цаасны танилцуулга

8.3. ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ



“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯЛТИ ТЭК”  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ  
КОМПАНИЙН ДҮРЭМ  
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)





НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

9011856540

2023 12 30

*Алсуу*

1.1 "Бичил Эй Би Эс лоялти ТЗК" ХХК /цаашид "Компани" эсхүл "ТЗК" гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид "Дүрэм" гэх/-ийн хүрээнд үйл ажиллагва явуулах хязгварлагдмал хариуцлагатай компани байна.

## 1.2 Компанийн оноосон нэр (монголоор)

- а) Бутан нэр "Бичил Эй Би Эс лоялти Тусгай Зориулалтын Компани" ХХК, төвчилсон нэр нь "Бичил Эй Би Эс лоялти ТЗК" ХХК  
 б) Англи нэр буюу төвчилсон нэр "Bichill ABS loyalty Special Purposed Company" LLC буюу "Bichill ABS loyalty SPC" LLC

## 1.3 Компанийн оршин байгаа газар:

УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11 -р хороо, 7-р хороолол, Нагаси нуурын гудамж 101 барилга, 705 тоот

Харилцах утасны дугаар: 99119632

## 1.4 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа зээмшигчийн мэдээлэл

Хувьцаа зээмшигчийн мэдээлэл	Регистрийн дугаар	Хаяг	Утас
Бичил глобус финанс ББСБ ХХК	5729718	УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11 -р хороо, 7-р хороолол, Нагаси нуурын гудамж 101 барилга, 705 тоот	99119632 70002020

- 1.5 Компани нь өөрийн албан бичгийн хэвлэлийг хуудас, тэмдэгтэй байна.  
 1.6 Компани нь ажилтангүй ба өөрийн үйл ажиллагавг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гураандаг этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.  
 1.7 Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тосгоор илэрхийлгэдэх ба түүний боломжийн эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ТҮЛ АЖИЛЛАГАА

2.1 Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани байх багаад зрхлах цорын ганц үйл ажиллагав нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө худалдан авах, автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах болон тухайн худалдан авах үнэт цаас гаргахтай холбоотой буюу тэдгээрийн дагуу хийгдэх энэхүү дүрмийн 2.3-т заасан бусад үйл ажиллагав байна.

2.2 Компанийн зорилго. Компани нь автомашин барьцаалсан зээлүүдийг баглан худалдан





УИХ ЧЛГД

БҮРГГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

СЗХ

2024 01 20

БҮРГГЭВ

№ 01

авч. тэдгээркүйг өөрийн хөрөнгө болон санхүүтийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан Автомашин барьцаалсан зээлзүүдийн төлбөрийг төлөх үүднээс автомашин барьцаалсан зээлзэр баталгаажсан үнэт цаас гаргана.

### 2.3 Компани нь дарвах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- 2.3.1 Автомашин барьцаалсан зээл худалдах авах;
- 2.3.2 Автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- 2.3.3 Автомашин барьцаалсан зээл худалдах авах болон автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор гэрээг байгуулах;
- 2.3.4 Баталгаает үнэт цаас гаргах, түүний төлбөрийг хэрэлжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг байгуулах;
- 2.3.5 Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт зассан компанийн аливаав үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэлжүүлэх;
- 2.3.6 Бизнесийн үйл ажиллагааны явацад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн зэрэлзэлт үдидах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
- 2.3.7 Мөнгөн хөрөнгийг Санхүүтийн Зохицуулах Хорооноос хориглоогүй санхүүтийн хэрэгсэлд зэрэдэл үр өвөөжийг тооцрагж зохицой түвшинг харгалзан байршуулах;
- 2.3.8 Хууль болон дүрэмд зассан бусад.

### 2.4 Компани дарвах үйл ажиллагааг эрхлэхийг хориглондо.

- 2.4.1 Дүрэмд заснаар өөр үйл ажиллагааг эрхлах, эсхүл үйл ажиллагааг явуулах;
- 2.4.2 Баталгаает үнэт цаасыг худалдсанас олсон орлогогоос зргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;
